

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР

Өдөр +2  
Шөнө -4

УЛС ТӨР

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД  
Д.ГАНБАТ ТӨМӨР ЗАМЫН САЛБАРЫН  
ТӨЛӨӨЛЛҮҮДТЭЙ УУЛЗЛАА

II нүүрт

ОНИЦЛОХ ХУУДАС

ХӨРГӨГЧТЭЙ БАЙСНЫХАА ТӨЛӨӨ  
ХҮҮХДИЙН МӨНГӨӨ ХАСУУЛЛАА

V нүүрт

Дугаарын 60 мөр

ҮЗЭЛ БОДОЛ

## ЗӨВ ЖИШИГ

Шалган бүртгэх  
товчоодыг ухаалаг  
болгоё

Ж.ОТГОНМЯГМАР

Н.ПУНЦАГБОЛД

Кондукторт чичлүүлэн байж мөнгөө төлж, оронд нь хуруун чинээ цаас авдаг байсан манайхан нийтийн тээврийн үйлчилгээг ухаалаг болгох сургаар шоолон инээж байсан цаг саяхан. “Битгий сэрүүн зүүдлээд бай, манай монголчууд тэр ухаалаг автобусны буудлыг чинь хоногт нь хага цохиод, тэр картыг чинь авах ч үгүй, үнэ төлбөргүй зорчих болно” гэх мэгчилэн нийслэлчүүдийг басамжилсан ч гэх үү, доромжилсон ч гэх үү сөрөг зүйлийг ярьж, бичих хүн олон байлаа. Энэ нь дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын нийтийн тээврийн смарт картын үйлчилгээ манай улсын хувьд мөрөөдөл байсан үеийн харанхуй шүүмжлэл юм.

Үргэлжлэл нь III нүүрт

“Улс орныг ялсан намынх нь дарга ганц лидер нь авч явдаг юм шүү дээ. Та нар дэлхийн бүх туршлагыг хараарай. Тэр нам гарч ирээд улс орныг аваад явчихлаа гэхээс илүү тэр лидер л гэдэг. Дэлхийн бусад оронд ийм л жишиг байдаг. Сингапур хамгийн тод жишээ нь байна. Солонгос байна. Дээр нь Герман, Итали, Англи, АНУ-ыг харахад үнэхээр лидер нь гарч ирээд л аваад явж байна шүү дээ” хэмээн саяхан өгсөн ярилцлагадаа Л.Пунцагболд байна билээ. Яг үнэн. Өнөөдөр манай улс эх орноо өөд нь татаад, хариуцлагаа үүрээд зөв бодлого боловсруулаад аваад явчих лидергүй болчихоод байна. Сая сонгуулийн дараа МАН үнэмлэхүй ялалт байгуулахад хүмүүс намын дарга М.Энхболдыг Ерөнхий сайд болно гэж харж байсан. Мөн Хууль зүйн, Сангийн, Хөдөлмөрийн сайдуудыг

тооцоолж, харж байлаа. Гэтэл юу болов, санаанд оромгүй томилгоо яваад л дууссан. Намын дарга нь өөрөө УИХ-ын дарга болоод суучихлаа. Өнөөх МАН-ын лидерүүд яагаад хойшоо суучихав. Эрх мэдэл, эд хөрөнгө нь залуучуудынхаасаа давахаа больчихно гэж баймааргүй л юм. Харин өнөөдөр Засгийн газар 100 хоногтойгоо золгох гэж байхад хийсэн бүтээсэн ажил алга. Бүхий л зүйлийг самарч, оронгоор нь эргүүлж, хасаж, танаж, нэрийг нь өөрчилж, төрийн алба төрөл садангаараа л дүүргэлээ. Өнөөх хамгийн их таалагдсан амлалт нь “Мэргэжлийн Засгийн газар байгуулна” гэх үг. Харамсалтай нь энэ амлалт яаж замхарсныг дээр дурьдсан жишээнээс та ойлгож байгаа байх. Зүгээр нэг уяачийг салбарын сайдаар томиллоо. Сангийн болоод Хөдөлмөр, нийгмийн

хамгааллын сайдын суудалд суучихаад байгаа хүмүүсийн талаар ч ярьж, бичвэл их зүйл бий. Ийм л Засгийн газар бүрэлдэж, ард түмний итгэлийн өөдөөс “ус цацсан”. МАН одоо залуучуудаа өмнөө барьсан, албан тушаалын наймаа хийсэн, ахмадууд, лидер гэж болохоор улстөрчид нь хий улстөржсөн байдалтай л байна. Тиймээс одооноос улс төрд зөв жишиг тогтоож, өөрчлөх цаг болж. Тухайлбал, ирэх 2020 оны сонгуулийн өмнө ялсан нам, эсвэл хэнийг Ерөнхий сайдаар ажиллуулахаа шууд зарлаж байх шаардлага байхгүй. АН ялбал тэр хүнийг бид Ерөнхий сайдаар ажиллуулаа гээд л гүйцээ. Ингээд ирвэл бусад нам ч гэсэн тэгж өрсөлдөнө. Яг үнэндээ улс орныг өөд нь татаж, зөв бодлого гаргаж чадах лидерээрээ л өрсөлдөнө гэсэн үг шүү дээ.

Үргэлжлэл нь III нүүрт

УИХ-ЫН ГИШҮҮН ТОЙРОГТОО...

## УИХ-ЫН ГИШҮҮН Д.ОЮУНХОРОЛ СОНГОГДСОН ТОЙРОГТОО АЖИЛЛАЛАА

УИХ-ын гишүүн, БОАЖ-ын сайд Д.Оюунхорол энэ амралтын өдрүүдэд өөрийн сонгогдсон Баянзүрх дүүргийн 49 дүгээр тойргийнхоо иргэд сонгогчидтой уулзаж, Засгийн газрын 100 хоногийн үйл ажиллагааг танилцуулж, иргэдийн санал хүсэлтийг сонслоо. Өнгөрөгч бямба гарагт 2, 21, 27 дугаар хорооны иргэдтэй уулзсан бол ням гарагт 1, 2, 7 дугаар хорооны иргэд сонгогчидтой уулзалт хийв. Тойргийнхонтойгоо уулзаж буй энэ удаагийн уулзалт мэдээж түүний анхных биш юм. Тэрбээр хичээлийн шинэ жил эхлэхийн өмнөхөн Тусгаар тогтнолын

ордонд иргэдтэйгээ уулзаж, 200 хүүхдэд хичээлийн хэрэгсэл, 12 оюутанд “Отгонтэнгэр” их сургуульд дөрвөн жил үнэ төлбөргүй сурах эрхийн бичиг гардуулж, иргэдтэйгээ санал бодлоо хуваалцсан. Уулзалтад оролцогчид УИХ-ын гишүүн Д.Оюунхоролыг тойргийнхоо иргэдтэй ойр ойрхон уулзаж, санал хүсэлтийг нь сонсч байгаад баярлаж буйгаа илэрхийлж байв. Баянзүрх дүүрэг нь хамгийн их хүн амтай, хамгийн их газар нутагтай дүүрэг. Энэ утгаараа захын гэр хорооллын иргэдэд төрийн үйлчилгээ хангалттай хүрдэггүй, гэрэл цахилгаангүй,

дэд бүтэц, амьдрах орчин, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийн асуудал хангалттай биш гээд тулгамдсан асуудал тус дүүрэгт чамгүй бий. Тиймээс нэн тэрүүнд шийдвэрлэх шаардлагатай гэж үзсэн зарим асуудлаасаа эрхэм гишүүн ажлаа эхлүүлжээ.

Тухайлбал, тус дүүргийн 21 дүгээр хорооны Жамсран уулын ар талын 52 дугаар байршлын 300 өрх тоггүй хэдэн жил болж байгаа аж. Тэдгээр өрхийг гэрэл цахилгаантай болгох ажлыг шийдвэрлэсэн юм.

Үргэлжлэл нь IV нүүрт

ДОТОР НҮҮРТ



ДОНАЛД  
ТРАМП НЭРЭЭ  
ТАТАХГҮЙ

6

ОНИЦЛОХ МЭДЭЭ

Тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой  
хуулийн төслийг өргөн мэдүүлэв



Э.МӨНХ

УИХ-ын гишүүдийн хамтран санаачилж, боловсруулсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын гишүүн С.Чинзориг, Б.Саранчимэг, Д.Тогтохсүрэн, Ц.Цогзолмаа, Л.Элдэв-Очир нар өнгөрсөн баасан гарагт өргөн мэдүүллээ. Эхчүүдийн хүүхэд төрүүлж, өсгөсөн хөдөлмөрийг бодитой үнэлж нийгмийн баталгааг нь сайжруулах зорилгоор хүүхэд асарсан хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг тасалдуулахгүй төлөх, шимтгэл төлсөн нийт хугацаан дээр төрүүлж өсгөсөн хүүхэд бүрийн тоогоор 1.5 жил нэмж тооцох, эхчүүдэд даатгуулсан хэлбэрээс нь үл хамааран адил хувь хэмжээгээр жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгох хууль эрх зүйн орчин бүрдүүлэх зорилгоор уг хуулийн төслийг боловсруулжээ. Мөн эхчүүдийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг нийгмийн даатгалд даатгуулсан хэлбэрээс хамааруулан ялгаатай олгож байгаа нь ижил тохиолдлоор орлого олох боломжгүй болсон нөхцөлд сайн дураар даатгуулсан эхчүүд бага тэтгэмж авч эрх ашиг нь зөрчигддөг аж. Статистик тоо баримтаас үзвэл жилд 80 орчим мянган эх төрж, 90 гаруй мянган эх хүүхдээ асарч ажил хөдөлмөр эрхэлдэггүй байна. Нөгөөтэйгүүр хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон эхчүүдийн тэтгэвэр ижил цалин хөлснөөс ердийн нөхцөлөөр тогтоолгосон эхчүүдийн тэтгэвэрээс 10-15 хувиар доогуур байдаг аж. Мөн хөдөлмөрийн тааламжгүй нөхцөл, ажил, мэргэжлийн онцлогийг харгалзан тэтгэвэр эрт тогтоолгох болзол нөхцөлийг зохицуулсан байдаг хэдий ч энэ зохицуулалт нь байгаль, цаг уурын хараат байдалд биеийн хүчний хүнд хөдөлмөрийг ажил амралтын горимгүй эрхэлдэг малчдад хамаардаггүй байна. Манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 10 гаруй хувийг үйлдвэрлэж буй мал аж ахуйн салбарт 300 гаруй мянган малчин ажилладаг байна. Энэ нь нийт ажиллагчдын 30 орчим хувийг эзэлдэг. Эрхэлж буй хөдөлмөрийн онцлогоос хамааран хөдөлмөрийн чадвар эрт буурах, хүнд өвчин тусах, наснаасаа эрт өтлөх, харьцангуй эрт нас барах тохиолдол малчдын дунд түгээмэл байгаа юм. Үүнээс шалтгаалан залуучуудын мал аж ахуй эрхлэх сонирхол буурч, хот суурин руу шилжих болсноор хөдөө орон нутаг эзгүйрэх хандлагатай болж байна хэмээн хуулийн төсөл санаачлагч үзжээ. Тиймээс малчдад хөнгөлөлттэй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгох боломж олгох хууль эрх зүйн орчин бүрдүүлэх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байна.

PC mall. DELL ХААН БАНК

ЛИЗИНГИЙН ХҮҮ:  
ЖИЛИЙН  
8% БОЛМОО

ЗӨВХӨН DELL  
БРЭНДИЙН НӨҮТБҮҮК

7575-3535 www.pcmall.mn /PCmallOfficial

| ХААН банк |         |         |       | Хугалгаа хөгжлийн банк |         |           |         |         |
|-----------|---------|---------|-------|------------------------|---------|-----------|---------|---------|
|           | Авах    | Зарах   |       | Авах                   | Зарах   | Авах      | Зарах   |         |
| АМ.ДОЛЛАР | 2260.00 | 2278.00 | ФУНТ  | 2767.00                | 2869.00 | АМ.ДОЛЛАР | 2260.00 | 2277.00 |
| ЕВРО      | 2483.00 | 2554.00 | РУБЛЬ | 34.90                  | 38.00   | ЕВРО      | 2474.00 | 2579.00 |
| ИЕН       | 21.55   | 22.16   | ЮАНЬ  | 336.00                 | 341.00  | ИЕН       | 21.36   | 22.40   |
|           |         |         |       |                        |         | ФУНТ      | 2731.00 | 2848.00 |
|           |         |         |       |                        |         | РУБЛЬ     | 34.01   | 39.50   |
|           |         |         |       |                        |         | ЮАНЬ      | 336.00  | 340.90  |

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар



## УЛС ТӨР

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД Д.ГАНБАТ ТӨМӨР  
ЗАМЫН САЛБАРЫН ТӨЛӨӨЛЛҮҮДТЭЙ УУЛЗЛАА

Н.БАТЗАЯА

Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат өнгөрсөн баасан гарагт салбарынхаа төлөөлүүдтэй уулзаж, тэдний санал бодлыг сонсож байна. Мөн иргэний нисэхийн салбарынхантай уулзаж, харилцан санал солилцлоо. Энэхүү уулзалтад төмөр замын чиглэлээр үйлчилгээг хөгжүүлэхэд УБТЗ ХНН, МТЗ ТӨХК, Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулах нэгдсэн төв болон Болд төмөр ерөө гол зэрэг байгууллагын 60 гаруй төлөөлөл хамрагджээ.

Монгол Улсын Засгийн газар эмхлэн байгуулагдсаны 100 хоногийн хүрээнд Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын зүгээс хийж хэрэгжүүлсэн ажил, 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний талаар салбарынхантай ийнхүү зөвлөлдөж буй юм.

Уулзалтын үеэр салбарын сайд төмөр замын тээврийн салбарт

хэрэгжүүлэхээр төлөвлөж ирсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт удаашралтай явагдаж ирсэнийг нуусангүй. Дэлхийн эдийн засгийн хөгжилтэй уялдан Ази-Европын хооронд ачаа, тээврийн урсгал нэмэгдэж буй өнөө үед хоёр тивийг холбосон төмөр замуудын нэг болох Монгол Улсын төмөр замыг хамгийн дөт тээврийн коридор гэж дэлхий нийтээр харах болсон талаар уулзалтын эхэнд онцлолоо. Тиймээс ирэх дөрвөн жилд Монгол Улсын Засгийн газраас өөрийн орны төмөр замын нэвтрүүлэн өнгөрүүлэх чадварыг нэмэгдүүлэх, хөрш орнуудын төмөр замуудын галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагт нэгдэн орж, дамжин өнгөрүүлэх тээвэрлэлтийг оновчтой зохион байгуулах боломжийг бий болгоход анхаарч ажиллахаа илэрхийллээ. Мөн Улаанбаатар төмөр замын техникийн шинэчлэлтийг үргэлжлүүлэн хийх, БНХАУ, ОХУ-ыг холбосон эдийн засгийн коридор байгуулах ажлын хүрээнд төмөр замын тээврийн коридорын тоог



нэмэгдүүлэх бодлого баримтлан ажиллахаа шаардлага урган гарч байгааг ч хэлж байв.

Түүнчлэн УБТЗ-ын үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх, үргүй зардлыг багасгах, тарифын уянхатан бодлогыг боловсруулах, хөрш орнуудын техникийн хөгжилтэй зэрэгцэн алхах боломжийг бий болгохын тулд

техник, технологийн дэвшилтэт шинэчлэлийг нэвтрүүлэх, шинэ санаачлагыг хөгжүүлэн дэмжих, түүнтэй зэрэгцүүлэн боловсон хүчнийг бэлтгэх, тэдгээрийн мэргэшүүлэх, чадавхижуулах зэрэг чиглэлд анхаарах шаардлагатай байгаа аж.

Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат шинээр байгуулагдсан Засгийн газрын 100 хоногийн хугацаанд төмөр замын тээврийн салбарыг хөгжүүлэх ажлын хүрээнд хийсэн зарим ажлуудыг танилцуулсан юм.

Үндэсний тээвэр, логистикийн сүлжээг хөгжүүлэх үйлчилгээ, хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд хийгдэж байгаа Дорноговь аймгийн Замын-Үүд суманд хэрэгжүүлж байгаа Бүс нутгийн тээвэр, логистикийн төвийг хөгжүүлэх төсөлд шаардлагатай төмөр зам, барилгын ажилд ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах зөвшөөрлийг Засгийн газраар шийдвэрлүүлжээ. Энэхүү логистикийн төвийн барилгын ажлыг 2019 онд дуусгахаар төлөвлөжээ. Мөн Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн тээврийн дэд сайд нарын түвшиний гурван талт уулзалтыг 11 дүгээр сард эх орондоо зохион байгуулахаар төлөвлөн бэлтгэл ажлыг хангасан байна. Мөн Монгол-Тяньжины худалдаа хамтын ажиллагааны хүрээнд БНХАУ-ын Дунзаны чөлөөт худалдааны боомт бүсийн 10 га газарт тээвэр логистикийн төв төсөл, Хөтөгийн уурхайгаас Сүхбаатар аймгийн Бичигтийн боомт хүртэлх төмөр замын ТЭЗҮ-

ийг боловсруулах, “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн хэрэгцээнд импортлох дизель түлшний онцгой албан татвараас чөлөөлөх зэрэг олон ажлууд биеллээ олж буй талаар сайд Д.Ганбат онцлолоо.

Тэрээр Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төмөр замын тээврийн салбарт цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа ажлуудаа танилцуулсан юм. Тухайлбал, 2017 онд Хөт-Бичигт чиглэлийн 222 км төмөр замын, “Шивээхүрэн-Сэхэ” боомтын 13 км төмөр замын, Эрдэнэт-Овоот чиглэлийн 547 км төмөр замын барилгын ажлыг эхлүүлж 2020 онд барилгын ажлыг хийж дуусгахаар төлөвлөж байгааг дуулгав. Мөн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 267 км төмөр замыг барих ажлыг үргэлжлүүлэн 2018 онд ашиглалтанд оруулахаар төлөвлөжээ.

Төмөр замын тээврийн салбарт дээрх томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр 2020 он гэхэд Монгол Улсын дотоодын төмөр замын сүлжээний урт 1200 орчим км-ээр нэмэгдэх юм. Үүний үр дүнд Монгол Улсын дэд бүтцийн өрсөлдөх чадвар дээшилж, уул уурхайн бүтээгдэхүүнийг тээвэрлэх тээврийн зардал буурах, уурхайн олборлолт, нийлүүлэлтийн хэмжээг нэмэгдүүлэх боломжтой гэдгийг салбарынхан хэлж байлаа. Ингэснээр орон нутагт ажлын байр нэмэгдэх, тээвэр, логистикийн сүлжээний үйлчилгээ, хүртээмж сайжрах зэрэг эдийн засаг, нийгмийн өндөр өгөөжийг бий болгох ач холбогдолтой юм байна.



МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## ТАЗ-ийн Ажлын албаны даргыг томиллоо

Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны даргын сонгон шалгаруулалтад дөрвөн иргэн оролцож хамгийн өндөр оноо авсан Д.Баатарсайханыг өнгөрсөн ажлын өдрүүдэд Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны даргад нэр дэвшүүлж, томилсон байна. Мөн Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журамд өөрчлөлт оруулж, Төрийн албаны зөвлөлийн Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийг байгуулж, Хил хамгаалах ерөнхий газар, Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталсан тухай эх сурвалж мэдээллээ. Төрийн албаны зөвлөлийн 31 дүгээр хуралдаанаар Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны даргын, Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын сонгон шалгаруулалтын дүнг хэлэлцсэн байна. Ингээд сонгон шалгаруулалтад хамгийн өндөр оноо авсан Ө.Баянмөнхийг Өмнөговь аймгийн Тамгын газрын даргаар томилуулахаар нэр дэвшүүлж, Засгийн газарт саналаа хүргүүлэхээр шийдвэрлэсэн байна.

## Ж.Мөнхбат: “Эрдэнэт”-ийн 49 хувьтай холбоотой асуудлыг шалгуулж, дүнг нь ил тод мэдээлнэ

Сүүлийн үед олны анхаарлын төвд ороод байгаа “Эрдэнэт” үйлдвэрийн 49 хувьтай холбоотой асуудал УИХ-ын чуулганы баасан гарагийн хуралдааны үеэр сөхөгдлөө. Үүнтэй холбогдуулж, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат болон Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт нар гишүүдийн асуултад хариулсан юм. Энэ үеэр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат “Монгол Улсын Засгийн газар 2016 оны аравдугаар сарын 05-ны өдрийн ээлжит хуралдаанаараа “Эрдэнэт” үйлдвэртэй холбоотой асуудлыг шалгах Ажлын хэсгийн дүгнэлтийг хэлэлцэн тодорхой шийдвэр гаргасан. Тухайлбал, өмнөх Засгийн газрын шийдвэрийн дагуу төрийн мэдлийн 51 хувь нь хувийн мэдэлд шилжсэнийг засах, Сангийн сайд, Гадаад хэргийн сайдын хууль зөрчсөн байх магадлалтай тушаалыг хүчингүй болгох, улмаар бүх мэдээллийг УИХ-ын чуулган, хэвлэл мэдээлэл, ард иргэдэд ил тод хүргэхээр болсон билээ. “Эрдэнэт” үйлдвэрийн 49 хувийн асуудлаар энэ Засгийн газар шуурхай арга хэмжээ авсан. Хэн нь зөв шийдвэр гаргаж, хэн нь буруу шийдвэр гаргасан гэдгийг шалгаж, асуудалд цэг тавих хэрэгтэй. Энэ оны зургадугаар сарын 13-ны өдөр хуралдсан Засгийн газрын протокол нууц байсныг ил болгоно. Бүх шийдвэр, хэлсэн үг зэрэг нь гарын үсэгтэйгээ байгаа. Асуудлыг нууж хайцаалахгүй. Иймээс хууль хяналтын байгууллагдах хандаж шалгуулахаар бэлтгэж байна. Хэрвээ хууль зөрчсөн, буруутай нь тогтоогдвол тухайн хүмүүс хариуцлага хүлээх ёстой. Үнэн зөвийг тодруулсны дараа УИХ-д маш яаралтай өргөн барьж танилцуулна. Мөн хэвлэл мэдээлэл, ард иргэдэд ил тод мэдээлнэ” гэсэн юм.

ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

## Чуулганы хуралдааныг завсарлуулахгүй байхаар шийдвэрлэв

УИХ-ын 2016 оны намрын ээлжит чуулганы баасан гарагийн үдээс өмнөх нэгдсэн хуралдаан 52.6 хувийн ирцтэйгээр эхэлж, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж, гишүүдийн 69.8 хувь нь дэмжсэн учир хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлжээ. Дараа нь Үндсэн хуулийн цэцийн 2016 оны есдүгээр дүгнэлтийг УИХ-ын чуулганы хуралдаанаар хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Сонгуулийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэлээ. Энэ асуудлыг хэлэлцсэн талаархи Төрийн байгуулалтын байнгын

хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Н.Цэрэнбат танилцуулсан. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүн байсангүй. Иймд цэцийн дүгнэлтийг зөвшөөрсөнтэй холбогдуулан Сонгуулийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанаар баталлаа.

Олон нийтийн цахим сүлжээгээр орон нутгийн сонгууль дуусгал УИХ-ын чуулганы хуралдааныг завсарлуулна гэх мэдээлэл цацагдаад байсан. Тэгвэл УИХ-ын даргын дэргэдэх зөвлөлийн хуралдаан өнгөрсөн баасан гарагт болж, ирэх долоо хоногт УИХ, байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлын дарааллыг

МЭДЭЭЛЭЛ

## УИХ-ын гишүүд мод тарив



Гэрэл зургийг Г.АРИУУЖИН

Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр өнгөрсөн ямба гарагт тохиосон билээ. Тэгвэл энэ өдөр УИХ-ын гишүүд, УИХ-ын Тамгын газрын ажилтнууд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд мод тарилла. Мод тарих үндэсний өдөрт зориулсан зургаа дахь удаагийн өдөрлөгийн нээлтэд нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболд, УИХ-ын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Ц.Гарамжав, УИХ-ын гишүүн А.Ундармаа, Б.Саранчимэг, М.Оюунчимэг, Д.Ганболд, УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Цолмон нар оролцсон юм. Энэхүү

өдөрлөгт УИХ-ын Тамгын газар болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, НЗЦТГ, нийслэлийн Нийтийн тээврийн газар, “Орчлон” дунд сургууль зэрэг төр, хувийн хэвшлийн байгууллага, иргэдийн төлөөлөл оролцож, таван төрлийн 500 гаруй мод тарив. 975 га талбай бүхий Азидаа хамгийн томд тооцогдох Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд нийт 10 мянга гаруй

мод буттай болсон бөгөөд тэдгээрийн ургалт нь 90 гаруй хувьтай байгаа ажээ. Мод тарих ажиллагаа дууссаны дараа УИХ-ын Тамгын газрын ажилтнууд Үндэсний цэцэрлэгт хүрээлэн дэх “Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жил, Ялалтын 70 жилийн ойд зориулсан УИХ-ын гишүүдийн байгуулсан төгөл”-ийг эргэж, арчилж тордлоо.

**МОНГОЛЫН МЭДЭЭ**  
18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: **С.ГАНТОГОО**

Орлогч эрхлэгч: **Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158**

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: **Э.ЭНХЦЭЦЭГ 88873012**

Ахлах редактор: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: **Н.ПУНЦАГБОЛД 88096454**

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Гэрэл зургийн алба: **Г.АРИУУЖИН 96017873**

Компьютерийн алба: **Б.ГАНЗОРИГ 99998796**

Маркетинг, зар сурталчлаганы алба: **Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710**

Захиалга, борлуулалтын алба: **М.ДАВААДУЛАМ 99042510**  
**Э.САЙНЗАЯА 99197866**

Дугаарыг эрхэлсэн: **Н.ПУНЦАГБОЛД**

Улсын бүртгэлийн дугаар: 907300528  
Индекс: 100757

Редакцийн хаяг: **Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот**

Харилцах утас, факс: **976-70113551**

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэл үйлдвэрт хэвлэв.



# ҮЗЭЛ БОДОЛ

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



ҮЗЭЛ БОДОЛ



# ЗӨВ ЖИШИГ

...Одоо энэ жишигийг УИХ-ын сонгуульд нэвтрүүлэ. Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж хүртэл сонгуулийн өмнө хэнийг Ерөнхий сайдаар ажиллуулахаа зарладаг байвал сайн хэмээн хэлж л байсан. Бид зүгээр л намын нэр харж сонголтоо хийж ханалаа...

өрнөж байна. Улаанбаатар хотын гудамж талбай бүхэнд нэр дэвшигчдийн зурагтай самбар харагдаж байгаа. Тэр дундаас хамгийн сонирхол татсан нэг сурталчилгааны самбар байгаа нь Баянгол дүүргийн АН-аас хийж буй реклам. Тодруулбал, хэрвээ Баянгол дүүргэрт АН-ынхан ялалт байгуулж чадвал УИХ-ын гишүүн асан С.Одонтуяаг Засаг даргаар ажиллуулахаар шийдвэрлэсэн юм байна. Одоо өнөө нэхээд байгаа зөв жишиг чинь энэ шүү дээ. Шууд л Баянгол дүүргэрт АН лидерээрээ өрсөлдөх гэж байгаа хэрэг. С.Одонтуяа бол 2008 онд НИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдож, Баянгол дүүргийн төлөө ажиллаж ирсэн хүн. Энэ дүүргээс 2012 онд УИХ-ын гишүүнээр сонгогдож байсан. Гишүүн байх хугацаандаа шинэ хүн шиг суралцах гэж ажиллаагүй. Бусад эмэгтэй холбооны Ерөнхийлөгчөөр ажилласан гээд зах зухаас нь дурьдахад ямархуу энтэй улстөрч болох нь харагдана. УИХ-ын гишүүн байх хугацаандаа Баянгол дүүргэрт хийж, хэрэгжүүлсэн ажил ч их. Ийм чадвартай улстөрчийг Баянгол дүүргийн Засаг даргаар ажиллуулаа гээд зарлачихаар бусад нам, эвсэл ч бас лидерээрээ өрсөлдөх шаардлагатай болж байгаа юм. 2012-2016 онд Баянгол дүүргийн Засаг даргаар Д.Оросоо ажиллаж байсан. Бас л АН-ынх. Дөрвөн жил Засаг даргаар ажиллахаа

УИХ-ын гишүүдтэйгээ нягт хамтарч, дүүрэгтээ чамгүй ажил хийж, хэрэгжүүлж чадсан хүн. Дүүрэгтээ бол лидер шүү дээ. Гэтэл одоо түүнээс илүү чадвартай, лидерийг хэрвээ АН ялбал Баянголын Засаг даргаар ажиллуулаа гээд мэдэгдчихээр сөрөг хүчнүүдийн эсрэг хийж буй том цохилт мөн биз. Хамгийн хүчтэй өрсөлдөгч болох МАН одоо яах вэ. Иргэд АН ялбал С.Одонтуяа Засаг дарга болгох юм байна. МАН ялбал хэн болох юм бол гэж харна шүү дээ. Харьцуула, шинжинэ. Зөв жишиг ингэж л тогтдог юм байна. Түүнийг Баянголын АН эхлүүлж чадлаа. Хөдөө зарим сумдад ч гэсэн энэ жишигийг ашиглаж эхэлсэн байна билээ. Өнгөрсөн дөрвөн жилд маш сайн ажилласан Засаг даргаа дахиулахыг хүсвэл энэ намын дэвшигчдийг сонгоорой гэж ухуулаад л явж байна. Одоо энэ жишигийг УИХ-ын сонгуульд нэвтрүүлэ. Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж хүртэл сонгуулийн өмнө хэнийг Ерөнхий сайдаар ажиллуулахаа зарладаг байвал сайн хэмээн хэлж л байсан. Бид зүгээр л намын нэр харж сонголтоо хийж ханалаа. Сая сонгуулиар ч тэгж л сонгосон, ард түмэн. Одоо УИХ-д дүүрэн "бор халзан хонинууд" суугаад, "майлалдаж" байна. Юу хийж, ямар бодлого хэрэгжүүлэхээ ч мэдэхгүй байна гэхэд хилсдэхгүй Харин лидер харж сонгосон бол өдийд бид цалин мөнгө, тэтгэвэр, шаардлагатай урамшуулал, тэтгэмжүүдийг хүрсэн төвшнөөс нь буулгалаа гэж бухимдаад сууж байхгүй л байсан болов уу.

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Хэрвээ сая сонгуулиар МАН-ынхан "Хэрвээ манай нам ялбал Ерөнхий сайдаар Ж.Эрдэнэбатыг, Сангийн сайдаар Б.Чойжилсүрэнг ажиллуула" гэж мэдэгдсэн бол яах байсан бол.

Баянголын Ардчилсан намынхан зөв жишиг тогтоолоо

Яг энэ өдрүүдэд орон нутгийн сонгуулийн сурталчилгаа ид

Дугаарын 60 мөр

## Шалган бүртгэх товчоодыг ухаалаг болгоё

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Харин одоо "Өө энэ нийслэлчүүд чинь хэн нэгнээр чичлүүлэхгүйгээр соёлтой боловсон үйчлүүлж чаддаг юм байна. Ухаалаг автобусны буудал дээр бие засахгүй, эвдэж, хагалахгүй хайрлаж, харамлах ухамсартай юм байна" хэмээн магтах хүн олдохгүй байгаа ч "Ухаалаг үйлчилгээ"-г Мянгуужингийн үлгэр байжээ гэх хүн одоо л лав алга. Тиймээс ухаалаг үйлчилгээнээс ухраагүй харин ч боломжтой бүгдийг ухаалаг болгож, дэлхий дахинтай хөл нийлүүлэн алхах хэрэгтэй байна. Монголчууд бид ухаалаг системтэй хөл нийлүүлэн алхаж чадна гэдгийг энэ мэт олон зүйлээр батлаад байгаа шүү дээ. Хамгийн ойрын хугацаанд шийдэж болох нэг зүйл бол хотоос гардаг, ордог товчоодын асуудал. Уг нь аль 2013 онд нийслэлийн хөрөнгөөр хотоос баруун чиглэлийн аймгууд руу гардаг 22-ын шалган бүртгэх товчоог бүрэн автомат тоног төхөөрөмж бүхий хаалттай болгосон. Энэхүү хаалт нь тээврийн хэрэгслийн улсын дугаарыг бүртгэх дугаар танилгын системтэй бөгөөд хоёр секундний дотор нээгдэж хаагдана. Дугаар танилгын систем буюу хяналтын камерыг нийслэлийн Авто замын газрын төв сервер дээр шууд хянаж байхаар болсон. Гэтэл бөөн хөрөнгө мөнгө зарж хийсэн энэхүү ажил өнөөдөр хэнд ч хэрэггүй хог болоод удаж байна. Саяхан сэтгүүлч миний бие хөдөө явахаар тус шалган бүртгэх товчоогоор гарсан. Уг нь 22-ын товчоо гардаг, ордог 10 эгнээтэй.

Гэтэл одоо гардаг нэг, ордог нэг эгнээ нь л ажилладаг юм билээ. Харин бусад эгнээ томоос том чулуугаар хаачихсан байна. Мэдээж хотоосоо гарах олон эгнээ замаар очсон бүх машин шалган дээр очоод нэг эгнээнд ороод түгжирч орших нь тэр. Ойролцоогоор 20-30 минут хүлээсний эцэст сая нэг миний нэвтрэх ээлж боллоо. Энэ үеэр "Энэ олон эгнээтэй шалган бүртгэх байхад яагаад ганцхан эгнээг нь ажиллуулдаг юм бэ, тэгээд мөнгө хураахдаа хурдан шуурхай үйлчилж болдоггүй юм уу" хэмээн тодруулсан юм. Харин мөнгө хураагч гээд олон юм яриад байгаа хүмүүсийг чинь яах юм" хэмээн бухимдан загнаж, мөнгө хавчиж авдаг урт иштэй төмрөө машины цонхоор сарвайсан юм. Уг нь ухаалаг болгоод дугаар танилгын систем буюу хяналтын камертай болсон юм чинь энэ мэт бүдүүлэг нөхдүүдэд элдэв хоёроороо хэлүүлэхгүй 22-ын товчоогоор нэвтрэх бүрэн боломжтой баймаар. Өөрөөр хэлбэл, зөрчлийн торгуулийг гэрийн хаягаар явуулаад авдаг шиг замын төлбөрийг хамтад нь ирүүлчихэж яагаад болохгүй гэж. Замыг нь тавиад, шалган нэвтрүүлэхийг нь тохижуулчихсан байхад түүнийг ашиглаж чадахгүй бүдүүлэг байж болохгүй биз дээ. Энэ чинь бэлэн хоол байхад халбагадаад ам руугаа хийж өгөхийг нь хүлээгээд хэвтэж байгаагаас огт ялгаа алга. Тиймээс бүх зүйл нь бэлэн товчоогоо ухаалаг системд нэвтрүүлээд, дараа дараагийн шалган бүртгэх товчоодоо ч ухаалаг болгоод өгөөч, Хотын дарга аа.

## ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР

Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1, 81.2 дахь заалтыг үндэслэн "Багануур" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулалтыг зарлаж байна.

- Тавигдах шаардлага:**
- 1.Уул уурхайн салбартай холбоотой ажиллаж байсан, мэргэшсэн байх;
  - 2.Инженер, Эдийн засагч, Нягтлан бодох бүртгэл, Эрх зүйч мэргэжилтэй байх;
  - 3.Сүүлийн 3 жилийн хугацаанд тус компанид эрх бүхий албан тушаал хашаагүй байх, мөн ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг, өрсөлдөгч аж ахуйн нэгж байгууллагад ажилладаггүй байх;
  - 4.Компанитай нэгдмэл сонирхолгүй бөгөөд нэгдмэл сонирхолтой этгээдийг төлөөлөхгүй байх;
  - 5.Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн бусад гишүүдтэй нэгдмэл сонирхолгүй байх;
  - 6.Компанийн томоохон хэрэглэгчийн хяналтын багц эзэмшигч,эрх бүхий албан тушаалтан биш байх /нэг жилд тухайн харилцагчтай хийсэн хэлцлийн нийт дүн нь компанийн нийт активийн 10 хувиас дээш хувьтай тэнцэж байвал томоохон харилцагч гэж үзнэ/;
  - 7.Нэр дэвшигч өөрөө эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд компанийн энгийн хувьцааны таваас дээш хувийг эзэмшдэггүй байх;
  - 8.Төрийн үйлчилгээг тооцохгүйгээр төрийн алба хашдаггүй байх;

- СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХЫГ ХЯЗГААРЛАХ НӨХЦӨЛ:**
- Тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг нь шүүхийн шийдвэрээр хассан,
  - Төрийн захиргааны болон төрийн улс төрийн албан тушаал эрхэлдэг, БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ:
  - Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт
  - Төрийн албан хаагчийн анкет
  - Боловсролын диплом, үнэмлэх, мэргэшсэн, зөвлөх, докторын үнэмлэх, диплом
  - Иргэний үнэмлэхний нотариатаар баталгаажуулсан хуулбар
  - Нэр дэвшигчид тавигдах дээрхи 8 шаардлагыг хангасан тухайгаа тодорхойлонгараар бичсэн баталгаа, нотлох баримт бичгүүд

**СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН МАТЕРИАЛЫГ ХҮЛЭЭН АВАХ ХАЯГ:** Сүхбаатар дүүрэг, 1-р хороо Чингисийн өргөн чөлөө-15 Моннис Цамхаг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн байр 14 давхарт, "Багануур" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд авчирч өгнө үү . /утас:70110735, 99815690/

**МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ ХУГАЦАА:** 2016 оны 11 сарын 07-ны өдөр хүртэл дээрхи хаягаар хүлээн авна.

Хууль зүйн сайд асан Х.Мянгуужин



## ЭДИЙН ЗАСАГ

УИХ-ЫН ГИШҮҮН ТОЙРОГТОО...

УИХ-ЫН ГИШҮҮН Д.ОЮУНХОРОЛ  
СОНГОГДСОН ТОЙРОГТОО АЖИЛЛАЛАА

Үргэлжлэл.  
Түрүүч нь I нүүрт

Тэднээс гадна хичээл номоо хийх боломжгүй ахуйн хэрэглээний хөргөгч, зурагтаа ч ашиглаж чадахгүй нөхцөлд амьдарч байгаа айлуудыг тог цахилгаантай болгох асуудлыг Эрчим хүчний сайдад уламжилжээ. Түүнчлэн 21 дүгээр хорооны "Ачит сайхан" өрхийн эрүүл мэндийн төвөөс ирүүлсэн цэвэр усны шугаманд холбуулах, барилгын засвар хийлгэх, сантехникийн засвар хийлгэх 16.8 сая төгрөгийн санхүүжилт хүссэн хүсэлтийг Эрүүл мэндийн сайдад уламжилж, санхүүжилтийг нь шийдвэрлэж өгчээ. Мөн түргэн тусламжийн машин 21, 27 дугаар хорооны өрхийн эмнэлгүүдэд өгүүлэхээр Эрүүл мэндийн ямаар шийдвэрлүүлсэн гээд өнгөрсөн хоёр сар гаруйн хугацаанд их, бага гэлтгүй олон асуудлыг шийдвэрлэжээ. Уулзалтад оролцсон ахмадууд ахмадын

түрээсийн орон сууцанд оруулж өгөх, 70-аас дээш настай ахмадуудад олгохоор болсон "Насны хишиг"-ийн насыг наашлуулах гэх мэт хүсэлтийг олноор тавьж байлаа. Энэ үеэр 21 дүгээр хорооны иргэн Жавзанпагма "Д.Оюунхорол гишүүн маань тойргийнхоо иргэд сонгогчидтой уулзаж байгаад маш их баярлаж байна. Сонгогдсоноосоо хойш их бага гэлтгүй иргэд бидний өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэж байгаад баяртай байна" гэлээ.

УИХ-ын гишүүн Д.Оюунхорол "Өнгөрсөн хоёр сар гаруйн хугацаанд Баянзүрх дүүргийн аль нэг хорооны Засаг дарга, дүүргээс надад энэ асуудлыг шийдвэрлүүлээр байна, шийдвэрлэх ийм асуудал байна гэж нэг ч хүн албан ёсоор хандаагүй. Та бүхний яриаг сонсч байхад дүүргээс хийх ёстой олон асуудал орхигдсон байна. Аль нэг нам гэж талцалгүйгээр Баянзүрх дүүргийн иргэдийн төлөө үүнийг хийх ёстой гэж ажилдаа хандахгүй байгаа

нь харамсалтай байна. Ийм үзэл суртлаас болж иргэд хохирох ёсгүй" гэсэн юм.

Баянзүрх дүүргийг тулгамдаж байгаа хамгийн том асуудал нь 11 мянга гаруй хүн амтай хэрнээ төрийн өмчийн нэг ч сургууль, цэцэрлэг байхгүй хоёрдугаар хороо юм. Ирэх оны төсөвт тус хороонд сургууль, цэцэрлэг баруулах ажлыг суулгуулж байгаа бол Дарь-Эхийн зам дагаад үерийн ус зайлуулах хоолой хийх, 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Хөгжлийн болон хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдэд үйлчилдэг Сувилалын цэцэрлэг яслийн 10 дугаар цогцолборын нураад гурван жил барилгын цогцолборыг ирэх онд шийдвэрлүүлэхээр ажиллаж байгаагаа УИХ-ын гишүүн Д.Оюунхорол хэлсэн. "Өмнө сонгогдсон гишүүд дөрвөн жилд дөрөв ирвэл их юм болдог байсан бол Д.Оюунхорол гишүүн сонгогдоод дөрөвхөн сар болохдоо маш их юм хийлээ" гэж тойргийнх нь иргэд тун ам сайтай байна.

ТОМИЛОЛТ



Ж.МЯГМАР

УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбат өнгөрсөн амралтын өдрүүдэд Дундговь, Төв аймгуудад ажиллалаа. УИХ, нийслэлийн ИТХ-ын сонгууль өнгөрсөн зургадугаар сарын 19-нд болсон билээ. Сонгуулийн үр дүнгээр МАН үнэмлэхүй ялалт байгуулж, төрийн эрх

барих дээд байгууллагыг удирдаж байгаа. Тэгвэл МАН төрийн эрх барьсан өдрөөс эхлэн амласан амлалт болгон нь хууралт болж, төрийн алба төрлийнх болж эхэлсэнд ард түмэн бухимдалтай байна.

УИХ-ын сонгуулиас хойш гаргаж буй тэдний амласнаасаа ухарсан шийдвэрүүд орон нутагт ч мөн газар авчээ. Энэ тухай

УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбатыг Дундговь аймагт ажиллах үеэр албаны хүмүүс болон орон нутгийн иргэд хэлж байсан юм. Тухайлбал, Дундговь аймгийн ИТХ нийт 35 гишүүнээс бүрддэг аж. Үүнээс МАН 19, Ардчилсан нам 14 суудал авч, үлдсэнийг нь бие даагчид авчээ. Гэтэл сонгуулийн дараа МАН-аас сонгогдсон гишүүд долдугаар

сарын 22-нд хуралдах ИТХ-ын товоо нууцаар урагшлуулж, 19-нд хуралджээ. Улмаар энэ хуралдаанаар хурлын дарга болон Засаг даргынхаа нэрийг тодруулж, Ерөнхий сайдад бичиг явуулсан хууль бус явдал болсон байна.

**Ажлаа өг, үгүй бол дэлгүүрийн чинь тусгай зөвшөөрлийг цуцална гэжээ**

Үүнээс гадна өнгөрсөн 2014-2016 онд төрийн албанд шинээр ажилд орсон хүмүүсийг удаа дараа халж байгаа аж. Бүр газар, хэлтэс, албадыг нэг тушаалаар бүгдийг нь халж

байгаа тухай иргэд хэлж байна. Ажлаас халагдах өргөдлөө өг, өөрөө өргөдлөө өгөхүй бол найман нэрийн дэлгүүрийн чинь тусгай зөвшөөрлийг цуцална, танай аав Ардчилсан намынх байсан болохоор чамтай хамтарч ажиллахгүй гэсэн үзэл суртлыг гааруулж байгаа тухай тэд ярьсан юм. Харин өнгөрсөн дөрвөн жилд Дундговь аймагт хийсэн ажил, их бүтээн байгуулалтыг өрнүүлж, Улаанбаатараас Мандалговь чиглэлийн хатуу хучилттай замын ажлыг дуусгасан. Малын тэжээлийн үйлдвэртэй болсон, орон сууцжуулах хөтөлбөр гээд олон ажил хийсэнд орон нутгийн иргэд ам сайтай байна. Энэхүү ажлыг үргэлжлүүлэхийн төлөө

удахгүй болох орон нутгийн сонгуульдаа ч гэсэн бодолтой хандана гэдгийг хэлж байсан юм.

Харин УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбатыг Төв аймагт ажиллах үеэр мөн л төрийн албаны дээрх дарамтууд гаарч байгаа талаар уулзалтын эхэнд төлөө хөгжил дэвшилд нэмэр болох олон бүтээн байгуулалтыг Ардчилсан намаас сонгогдсон Баярбат тэргүүтэй удирдлагууд хийж байсан, харин одоо бүх ажил зогссон. Одоо зөвхөн ах дүү, хамаатан саднаа ажилд авах, ширээ сандлаа хуваарилах ажил эрчимтэй явагдаж байгаад сэтгэл дундаар байгаагаа хэлж байв.

## МОНГОЛЫН МЭДЭЭ

Манай сонины  
IV улирлын  
НЭМЭЛТ ЗАХИАЛГА  
ҮРГЭЛЖИЛЖ  
байна

Улиралд

44

дугаар

ЗАХИАЛГЫН ҮНЭ

15600



Монгол шуудан: 70078977  
УБ шуудан: 70127027  
Скай пост: 70121294  
Түгээмэл шуудан: 70115025

## “БАГАНУУР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

2016 оны 10 дугаар сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

“Багануур” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2016 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 14.00 цагт Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-15, Моннис цамхаг 14 давхар “Эрдэнэс Монгол” ХХК-ийн хурлын танхимд хуралдаж, дараах асуудлыг хэлэлцэнэ.

- 1) Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай.
- 2) Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний бүрэн эрхийн хугацааг дуусгавар болгох, гишүүдийг шинээр томилох тухай

- 3) Нэмж гаргах үнэт цаасыг бүртгэлээс хассантай холбогдуулан авах арга хэмжээний тухай.

Хуралдорлоцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөр, Хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 11 дүгээр сарын 14-ний өдрийн 13:00 цагаар тасалбар болгоно.

Хувьцаа эзэмшигч та бүхэн хурлын холбогдох материалтай 2016 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн “Багануур” ХК-ийн төлөөлөгчийн газар, харьяа брокер диллерийн компани дээрээ ирж танилцан хуралдаа идэвхтэй оролцоно уу.

Хурал хуралдах газрын хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-15, Моннис цамхаг 14 давхар “Эрдэнэс Монгол” ХХК-ийн хурлын танхим

Лавлах утас: 458940,

Хурал зохион байгуулах комиссын дарга:

Б.Ганбаатар, утас: 99815690, ganbaatar@erdenes-mongol.mn

Хурал зохион байгуулах комиссын гишүүд:

Д.Ганчимэг - “Багануур” ХК-ийн Хуулийн зөвлөх, 88082547

С.Одончимэг - “Багануур” ХК-ийн Хэвлэл

мэдээллийн ажилтан, 99044373,  
С.Батболд - “Багануур-Илч” ХХК-ийн Гүйцэтгэх захирал, 99002742



# ОНЦЛОХ ХУУДАС

## Сенсаацийн эргэн тойронг

# ХӨРГӨГЧТЭЙ БАЙСНЫХАА ТӨЛӨӨ ХҮҮХДИЙН МӨНГӨӨ ХАСУУЛЛАА

Монгол Улсад хүн амын өсөлтийг дэмжсэн бодлого бараг байхгүй. Тиймдээ ч манай улс гурван сая хүнтэй болох гэж 30-аад жилийг барсан. Одоо ч гэсэн хүн амын өсөлтийг дэмжсэн бодлого алга. Тийм болохоор дөрвөн саяулаа болох гэж 30 жилийг барах байх. Ганц хүн амын өсөлт рүү чиглэсэн болов уу гэх бодлого болох хүүхэд бүрт сард 20 мянган төгрөг өгдөг байсныг болиулах дээрээ тулчихаад байна. Эхний ээлжинд 60 хувьд нь олгоно. Үлдсэн 40 хувьд нь хэдэн жилийн дараа хүүтэйгээр мөнгийг нь өгнө ч гэх шиг “үлгэр” яриад сууж байна, эрх баригчид. Тэгвэл “Монголын мэдээ” сонин энэ удаагийн “Онцлох хуудас”-аараа хүүхдийн мөнгөний эргэн тойрон дахь асуудлыг хөндлөө.

### С.БЯМБАЦОГТ: БИД БҮХ ХҮҮХДЭД МӨНГӨ ОЛГОНО

**2016.10.07:** Хөргөгчтэй айлын хүүхдэд мөнгө олгохгүй ялгаварлалаа гэж ярьж байна. Тэгвэл С.Эрдэнэ гишүүн сайд байхдаа 5.7 тэрбум төгрөг зарцуулж, судалгаа хийсэн гэдэг юм. Тэгээд сахлын машинтай, хөргөгчтэй бол танайх баян гээд хүүхдийн мөнгө өгөхгүй болгосон. Энэ асуудлыг С.Эрдэнэ гишүүн сайд байхдаа УИХ-д оруулж ирж байсан. Үүнийг бид эсэргүүцсэн. Харин өнөөдрийн хувьд боломжтой айлын хүүхдүүдийн мөнгийг хуримтлуулж байгаад, 2019 оноос өгч эхэлж л гэж байгаа юм. Боломжгүй, одоо авъя гэж байгаа хүмүүс нь сар бүр 20 мянган төгрөгөө аваад яваг. Боломжтой айлын хүүхдүүдийнхийг хуримтлуулж байгаад 2019 оноос өгч эхэлнэ. Өмнө нь хөргөгчтэй, сахлын машинтай айлд хүүхдийн мөнгийг огт өгөхгүй байя гэсэн хуулийн төсөл оруулж ирж байсан. Энэ бас ялгаатай шүү.

### Ц.ТУВААН: ӨРХИЙН МЭДЭЭЛЛИЙН САНД БҮРТГЭЛТЭЙ БҮХ ХҮҮХДЭД МӨНГӨ ОЛГОНО

**2016.01.25:** УИХ-ын нэгдсэн чуулганаар өмнө нь гаргасан 103 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тогтоолын төсөл батлагдлаа. Уг төсөлд өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн 1-17 дугаар бүлэгт хамрагдах хүүхдэд мөнгө олгохоор тусгасныг өөрчлөн тус санд бүртгэлтэй бүх хүүхдэд олгохоор болсон. Мөн өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлж амжаагүй хүүхдийг бүртгэлд хамруулсан тохиолдолд хүүхэд бүрт 20 мянган төгрөг олгох эрх нь нээгдэнэ. Хэрэв тухайн иргэн нэгдүгээр сарын 31-ний дотор оршин суугаа хорооныхоо нийгмийн ажиглалтанд хандан өргөдлийн маягт бөглөсөн бол мэдээлэл хэдэн сард баталгаажсанаас үл хамааран хүүхдийн мөнгийг өргөдөл гаргасан сараас нь тооцож олгоно. Тухайлбал, ачааллаас хамааран нэгдүгээр сард өгсөн өргөдлийн баталгаажилтыг хоёрдугаар сард хийж болох юм. Хэрэв тухайн иргэн хоёрдугаар сарын 1-нд өрхийн амьжиргааны төвшин тогтоолох хүсэлт гаргасан бол нэгдүгээр сарын мөнгийг нөхөж олгох боломжгүй гэдгийг ойлгох хэрэгтэй.

### ТӨСВИЙН ТОДОТГОЛ ХИЙГДЭЭГҮЙ УЧРААС ХҮҮХДИЙН МӨНГӨ ОЛГОЛТ ТАСАРЧЭЭ

**2016.07.28:** Хүүхдийн мөнгийг энэ оны зургадугаар сар хүртэл олгоод, түр зогсоосон. Энэ нь төсвийн тодотгол хийгээгүйтэй холбоотой хэмээн албаны хүмүүс мэдэгдэж байсан юм. Энэ талаар цахим сайтууд “Хүүхдийн мөнгөний санхүүжилт тасраад байгаагай холбогдуулан Хүн ам нийгмийн халамжийн яамнаас тодруулахад Сангийн яамнаас санхүүжилт орж ирээгүй байна гэсэн хариулт өглөө. Саяхан байгуулагдсан шинэ засагтай холбоотойгоор төсвийн тодотгол хараахан хийгдээгүй байгаа учраас ийнхүү саатжээ. Энэ жилийн хувьд эхний зургаан сарын хүүхдийн мөнгийг банкуудаар дамжуулан олгочихсон. Үүнээс цаашид мөнгийг төсвийн тодотгол хийгдсэний дараа урьдын адил олгоно гэдгийг хэлж байна. Тиймээс салбар хариуцсан яамдууд санхүүжилтээ хүлээн ийнхүү түр саатаад байгаа юм байна. Энэ 2016 оны хувьд хүүхдийн халамжид зориулан 144 тэрбум төгрөг төсөвлөсөн. Харин үүнийг төсвийн тодотголоор хэрхэн зохицуулж яг эдийнээс олгож эхлэхийг хараахан шийдсэн зүйл алга. Арилжааны банкуудын хувьд хүүхдийн мөнгө асууж ирэх тохиолдол олон байгаа ч хэдийнээс олгож эхлэхийг эцэг эчүүдэд мэдээлэх боломжгүй байгаа тухай ярисан. Хүн ам нийгмийн хөгжлийн яамнаас ч энэ асуудлаар нарийн мэдээлэл өгөх боломжгүй засгийн газрын үйл ажиллагааг харж төсвийн тодотголыг хүлээж байгаа талаар хэллээ” хэмээн мэдээлж байсан юм.



### Х.БУЛГАНТУЯА: ИРЭХ ОНЫ ТӨСӨВТ МӨН ЗОРИЛТОД БҮЛЭГТ БАГТСАН ХҮҮХДИЙН МӨНГИЙГ ОЛГОХООР СУУЛГАСАН

**2016.10.04:** Энэ оны төсвийн тодотголд нийт хүүхдийн 60 хувьд нь хүүхдийн мөнгө олгохоор суулгасан. Хүүхдийн мөнгө олгох журам Засгийн газрын хуралдаанаар батлагдсан. Энэ дагуу хүүхдийн мөнгийг олгож эхлээд байна. 7-9 дүгээр сарын мөнгийг нэг дор олгож байгаа. Энэ хэвээрээ он дуустал олгоно. Ирэх оны төсөвт мөн зорилтод бүлэгт буюу 600 гаруй мянган хүүхдэд хүүхдийн мөнгө олгохоор болсон. Үүнд 214 тэрбум төгрөгийг суулгасан.

### С.ОДОНТУЯА: ХҮҮХДИЙН МӨНГИЙГ ЯЛГАВАРТАЙ ОЛГОХ НЬ ХУУЛЬ ЗӨРЧСӨН ҮЙЛДЭЛ

**2016.09.30:** УИХ-аас баталсан 38 дугаар тогтоолын дагуу амьжиргааны төвшиний 1-10 дугаар бүлэгт орсон айлын хүүхдэд сар бүр 20 мянган төгрөг бэлнээр олгохоор болсон. Харин уг бүлэгт хамаарахгүй бол хүүхдийн мөнгийг хадгаламж хэлбэрээр байршуулж, 2019 оноос бэлнээр авч болохоор заасан. Энэ нь олон хуулиудыг зөрчиж байна. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр бүлгийн 10 дугаар зүйлийн хоёр дахь хэсэг “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэснийг. Хоёрдугаар бүлгийн 14 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэг “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэснийг. Хоёрдугаар бүлгийн 16 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Хүнийг үндэс, угсаа, хэл арьсны өнгө, нас хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхан үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна” гэснийг. Хүүхдийн эрхийн тухай хуулийн 1.1-д “Хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байх” гэснийг зөрсөн. Мөн “Хүүхдийн эрхийн тухай конвенц”-ыг ч зөрчлөө. Энэ нь Монгол Улсын Үндсэн хууль дээдлэх, олон улсын гэрээгээ хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх зарчмыг уландаа гишгэсэн хариуцлагагүй үйлдэл.

## Сэтгүүлчийн өнцөг

# МАН ХҮҮХДҮҮДИЙГ ЯЛГАВАРЛАХДАА ДАРААГИЙН СОНГУУЛИА БОДОВ УУ

Н.ПУНЦАГБОЛД

Хүүхдийн мөнгө зургадугаар сараас хойш олгогдохгүй, дөрвөн сар тасарчихаад байсан. Харин өнгөрсөн баасан гарагаас 7-9 сэдүгээр сарын мөнгийг нэг дор өгч, олон иргэн цөөн ч болов хэдэн төгрөгтэй залгалаа. Гэхдээ эрх баригчид хүүхдүүдийн 60 хувьд нь мөнгө өгөөд, үлдсэн 40 хувийг нь орхисон. Тэдний тайлбарлаж байгаагаар 40 хувь нь мөнгө авах нэн шаардлагагүй учраас 2019 оноос хүүтэй нь өгөхөөр шийдсэн гээд байгаа. Мөн АН-ынхан өөрсдөө энэ асуудлыг эхлүүлсэн, С.Эрдэнэ сайд байхдаа бүр 40 хувьд нь огт мөнгө өгөхгүй байга гэсэн хуулийн төсөл оруулж ирсэн гээд л байна.

Хөргөгчтэй айл бол баян гээд мөнгө өгөхгүй ялгах асуудлыг өмнөх Засгийн газартай холбоод байгаа. Бас худлаа ч юм биш. Өрхийн мэдээллийн сан гээчийг байгуулж, амьжиргааны судалгаа хийсэн. Энэ судалгааны зорилго, ач холбогдол нь маш өндөр. Харин судалгаа хийхдээ л залхуураад, тэнэгтчихсэн болохоос. Одоо тэр жаахан барьцийг МАН-ынханатгачихаад, “Та нар эхлүүлсэн. Харин ч бүр хасна гэж байхад чинь бид болиулсан. Одоо бол бид дараа нь 40 хувьдаа өгчихнэ” гээд л сууж байна. Яахав, үе үеийн Засгийн газар, эрх баригчид урьд өмнөхөө үгүйсгэж, ухааж, барьцаж байдаг хойно. Яг үнэн чанартаа ам.долларын тэрбумтан

болчихсон хүний хүүхэд, ач эзэд сарын 20 мянган төгрөг шаардлагатай юу гэвэл үгүй шүү дээ. Тийм болохоор ангилгаад, ялгаад, салгаад, авах шаардлагагүй хүмүүст өгөхөө больчихвол зөв л байсан. Гэвч МАН-ынхан тухайн үед нь өөрсдөө улстөр хийгээд л болуулсан. Харин одоо эргээд асуудал өөрсөд дээр нь тулаад ирэхээр аятайхан зохицуулах гэж үзэж байгаа нь энэ. 2019 оноос хүүтэй нь өгнө ч гэх шиг. Одоо бол авах шаардлагатай хүмүүст нь өглөө гээд байгаа юм. Шаардлагатай, шаардлагагүй зардал гэж ялгах дээрээ тулсан бол арай өөр юм ярьж болно. МАН сонгуулийн өмнө мөрийн

хөтөлбөртөө хүүхдийн мөнгөний асуудлыг тусгасан. Өгнө л гэсэн. Нэгдүгээрт, тэр амлалтдаа хүрсэнгүй. Хоёрдугаарт, шаардлагатай, шаардлагагүй зардал гэдгээ ялгаж чадахгүй байна. Нэгэнт л өөрсдөө сур болоод, хүүхдээ ялгахгүй гэж тэнэгтчихээд, одоо дараа гэж хэлж болохгүй. Түүний оронд шаардлагагүй зардлаа танаад, хэт тансаглалаасаа татгалзаад, том өрөөгөө тохижуулахгүйгээр хэмнэсэн мөнгөө хүүдүүддээ өгчих хэрэгтэй биз дээ. Сардаа 20, 30 саяын цалин авдаг төрийн өмчит үйлдвэр, компаниудынхаа юу ч хийдэггүй “хувалз” шинжтэй дарга нарынхаа мөнгөнөөс жаахан танаад хүүхдүүддээ өгчихгүй яасан юм

бэ. Тэгвэл илүү гоё харагдах байлаа. Гишүүд, дарга нарынхаа сард утсаар ярьсан мөнгийг нь, том машинаар түгжрэлд явсан шатахууны зардлыг татвар төлөгчдийн мөнгөнөөс гаргаж байхаар хүүхдүүддээ өгчихгүй яв аа. Та нар, шаардлагатай, боломжтой, боломжгүй гээд ялгаж, салгаж мэддэг л юм байна шүү дээ. Тэгвэл яагаад зардлаа танах болохоороо шаардлагатай, шаардлагагүй гэдгээ ялгах нүдгүй болчихдог чинь сонин байна. Яг үнэндээ 2019 онд хүүтэй нь олгоно гэдэг бол сонгуулийн л амлалт. Нэгдүгээрт, орон нутгийн сонгуулийн өмнө нэрээ барахгүй байхын тулд өгсөн амлалт байлаа. Хоёрдугаарт, 2020

онд сонгууль болно. Тэрний өмнө 2019 онд хүүхдүүддээ амласан мөнгөө хүүтэй нь өгнө гээд төсвөөс баахан мөнгө гаргаж, цацах нь л дээ. Бас л дараагийн УИХ-ын сонгуулиа бодсон л юм шүү дээ. Түүнээс биш улс орны эдийн засаг хүнд байгаа юу, яах билээ гэж огт бодохгүй байна. Ийм л хоёр үзүүртэй амлалтыг МАН өгчихлөө. Өөрсдийнхөө хийсэн ажлыг бас үүгээр нуух гэж үзэж байна. Ай даа, эдний ард түмэнд таалагдах гэсэн өвчин үү. Улс орныг сүйрүүлнэ шүү. 2019 онд хэрвээ Монгол Улс энэ хэвээрээ л байвал тэд хаанаас мөнгө гаргаж хүүдүүдэд өгөх юм бол гэдэг асуулт ч бас үлдсэнийг санаарай.



# ДЭЛХИЙ

Б.ДАВААХҮҮ

Дэлхийн нэгэн хүчирхэг гүрэн болох АНУ-ын дараагийн Ерөнхийлөгч ирэх арваннэгдүгээр сарын 8-нд тодорно. Энэ сонгуульд Ардчилсан намаас Төрийн нарийн бичгийн дарга асан Хиллари Клинтон, Бүгд найрамдах намаас үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп нэр дэвшиж байгаа билээ. Тэгвэл хэдэн жилийн өмнө тэрбумтан Доналд Трампын ичгүүргүй аашилж байгаа видео бичлэг цацагдсанаар хэвлэл мэдээлэл, олон нийтийн зүгээс хүчтэй шүүмжлэх болсон юм. 2005 онд хийгдсэн дээрх видео бичлэгт Дональд Трамп нэгэн эмэгтэйд үнсэж, шалиг үг хэлж байгаа нь бичигджээ. АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвших болсноор Дональд Трампын татвар, хөрөнгийн мэдээлэл зэрэг нь олны анхаарлыг татах болсон төдийгүй өнгөрсөн амьдрал нь түүний эсрэг ашиглагдах зэвсэг болж байна. Гэсэн ч тэрбээр Цагаан ордны тэргүүний төлөөх өрсөлдөөнд бууж өгөхгүй гэдгээ мэдэгджээ. Тэрбумтан эр твиттер сүлжээнд богино хэмжээний бичлэг нийтэлж, түүгээрээ дамжуулан “Хэдэн жилийн өмнө болсон хувийн яриа байсан. Үүгээрээ хэн нэгнийг гутаан гомдоосон бол уучлал хүсье” хэмээж, уучлалт хүссэн юм.

Түүнчлэн, “Wall street journal” сонинд эл дуулиантай холбоотойгоор тайлбар өгч, “Ерөнхийлөгчийн сонгуулиас нэрээ татах магадлал тэг хувь” гэдгийг онцолсон байна. Дуулиан дагуулсан бичлэгтэй холбогдуулан Бүгд найрамдах намын нэр бүхий гишүүд ч Доналд Трампыг сонгуулиас нэрээ татахыг шаардах болсон. Тэгвэл энэ асуултад тэрбээр “Би бууж өгөхгүй” гэж хариулжээ. АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн хоёр дахь удаагийн хэл мэтгэлцээн манай цагаар өнөөдөр болно. Харин энэхүү мэтгэлцээнээс урьтаж, Трамп уучлалт хүссэн мэдэгдлийг твиттер сүлжээнд байршуулсан. Түүний хувьд албан ёсоор уучлалт гүйсэн энэ мэт тохиолдол сүүлийн 16 сарын хугацаанд анхных юм. Түүнчлэн тэрбээр өрсөлдөгчдөө дайралт хийж, Хиллари Клинтонд хандан түүний нөхөр АНУ-ын Ерөнхийлөгч асан Билл Клинтонь өнгөрсөн хугацаанд гаргасан дуулиант



## ДОНАЛД ТРАМП НЭРЭЭ ТАТАХГҮЙ

хэргийн талаар илүү ихийг мэтгэлцээний үеэр ярих болно гэдгээ мэдэгдэж, “Хэл мэтгэлцээн дээр уулзацгаая” хэмээсэн байна.

Хэл мэтгэлцээн Миссури мужийн Гэгээн Луйст болох билээ. Дашрамд сонирхуулахад, Доналд Трампын бичлэг ил болсны дараа зарим Бүгд найрамдахчууд түүнээс нүүр буруулж эхэлжээ. Тухайлбал, тус намын

лидерүүдийн нэг доод танхимын дарга Паул Райан бичлэгийг үзээд “Сэтгэл тавгүй болчихлоо” хэмээсэн бөгөөд мөн тэрбээр Уисконсин мужид болох намын үйл ажиллагаанд оролцох урилгаас гэнэт татгалзаж, оронд нь дэд Ерөнхийлөгчид нэр дэвшигч Майк Пенс оролцсон байдаг. Үүнээс гадна Бүгд Найрамдах намын нэр бүхий 12 сенатч, доод танхимын 12 гишүүн, мужийн гурван захирагч гэх

мэт албаны хүмүүс Трампыг дэмжихээс татгалзаж буйгаа мэдэгдсэн юм. Тодруулбал, Утах мужийн сенатч Майк Ли “Трампыг сонгуулийн компанитаас нэрээ татахыг шаардана” гэсэн бол Иллинойс мужийн сенатч Марк Кирк твиттертээ “Трамп нэрээ татах ёстой. Бүгд найрамдах нам яаралтай хуралдаж, нэр дэвшигчээ солих ёстой байна” хэмээн жиргэж байв.

## Жүжигчин эмэгтэй Албанийн ханхүүтай гэрлэв

Бүгд найрамдах Албани улсын нийслэл Тирана хотод Хуучин хааны гэр бүлд багтах Лека ханхүү тус улсын нэрт жүжигчин бүсгүй Элна Захариятай гэр бүл болж, нижгэр хуримын ёслолыг зохион байгуулжээ. Хуримын үйл ажиллагаанд Испанийн хатан София тэргүүтэй Ираны гүнж Фарах Диба, Югославын ханхүү Михайло Караджорджевич гэх мэт одоогийн болон хуучны хааны гэр бүлд багтаж байсан 20 гаруй хүндтэй төлөөлөгчид оролцсон байна. Лека ханхүү Албани улсын хамгийн сүүлчийн хаан болох нэгдүгээр Ахмет Зогу хааны цорын ганц үр удам нь юм. Тэрбээр Их Британийн Сандхурст эзэн хааны цэргийн академийг төгсч, одоо Албани улсын Гадаад хэргийн сайдын зөвлөхөөр ажилладаг аж. Харин түүний эхнэр Элна Захариа улсдаа нэр алдартай жүжигчин бөгөөд Парист театрын урлагийн чиглэлээр суралцаж байсан нэгэн гэнэ. Албанийн хааны удмын гэр бүлийн хуримын ёслол 1938 оноос хойш тохиосон анхны хурим болсноороо онцлог болжээ. Тус улсын нэгдүгээр Зогу хаан унгар бүсгүй Жералдине Апштейтай гэр бүл болсны дараа жил буюу 1939 онд фашист италийн цэргүүд Албани улсыг эзэлж байжээ. Энэ үед гэр бүлээрээ гадаад оронд дүрвэн зугтсан байдаг. Үүний дараа коммунизмын дарангуйлалд шилжсэн тус улсад хааны үр удмыг урвагчид хэмээн үзэх болсон бөгөөд нэг намын тогтолцоог эцэслэсэн 1990 оныг хүртэл хааны гэр бүл нутаг буцах боломжгүй болж байсан түүхтэй юм байна.

## Гүржийн сонгуульд эрх баригч нам яллаа

Хуучин Зөвлөлт холбоот улсын бүрэлдэхүүнд багтаж байсан Гүржид энэ сарын 8-ны өдөр парламентын сонгуулийн санал хураалт боллоо. Энэ удаагийн сонгуулийн парламентын сонгуулиар 150 төлөөлөгчийг сонгох бөгөөд орон нутгийн

мэдээллийн агентлагууд эрх баригч “Гүржийн мөрөөдөл” нам үнэмлэхүй олонхи болсон нь гарцан дахь санал асуулгаас тодорхой болсныг мэдэгдсэн юм. Түүнчлэн сонгуулийн дүн нэгэнт тодорхой болсны дараа эрх баригч намын дарга, тус улсын

Ерөнхий сайд Николоз Гиладури олонхи болсноо мэдэгдэж, ялалтаа зарласан бол ОХУ-ын эсрэг бодлого баримтлагч экс Ерөнхийлөгч Михеил Саакашвилигийн тэргүүлэх сөрөг хүчин “Үндэсний нэгдсэн хөдөлгөөн” нам санал тооллогын

эцсийн дүнг хүлээн гэдгээ мэдэгдэж байв. Сонгуулийн ерөнхий хорооноос танилцуулсан урьдчилсан дүнгээр Гүржийн мөрөөдөл нам парламентын 85 суудлыг авах бол сөрөг хүчин 65 суудлыг авах төлөв ажиглагдаж байлаа.

МЭДЭЭЛЭЛ

# АХЛАХ АНГИЙН СУРАГЧИД НИЙГМИЙН ДААТГАЛЫН МЭДЛЭГЭЭ ТЭЛЭВ

Н.БАТЗАЯА

Манай улсад Японы МЖАЙКА олон улсын байгууллагаас “Нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадвархийг бэхжүүлэх” төслийг хэрэгжүүлж байгаа билээ. Энэ хүрээнд хүрээнд өнгөрсөн баасан гарагт тус төслийн ахлах зөвлөх Ямашита Мамору “Шинэ Монгол” сургуулийн ахлах ангийн сурагчдад төслийнхөө талаар танилцуулж, нийгмийн даатгалын үйл ажиллагааны тухай лекц уншлаа. Тодруулбал, ахлах ангийн сурагчдад нийгмийн даатгалын ач холбогдол, японы болон манай улсын нийгмийн даатгалын системийн талаар ярьсан юм. Тэрбээр төслийн талаар “Монголд 65-аас дээш насныхан буюу хүн амд эзлэх өндөр настнуудын хувь өнөөдрийг хүртэл таван хувиас дотогш байсан. Гэтэл насжилтыг урт хугацаанд авч үзвэл, 2100 он гэхэд Монголын хүн амын дөрвөн хүн тутмын нэг нь 65-аас дээш насныхан болох хандлага ажиглагдаж байгаа. Европын орнуудын хувьд өндөр насжилтын хэмжээ аажимдаа нэмэгддэг байхад Азийн орнуудад насжилт хурдацтайгаар нэмэгдэж байна.

Жишээлбэл, Япон байна. 60 жилийн өмнө тус улсын хүн амын 43 хувийг залуус эзэлж, залуусын орон гэгддэг байлаа. Харин одоо тэтгэврийн насныхны хүн амд эзлэх хувь огцом нэмэгдсэн. Монголд ч гэсэн өндөр насжилт нэмэгдэнэ. Тиймээс үүнтэй холбогдуулан Япон улсын өнөөг хүртэл хэрэгжүүлж ирсэн Нийгмийн даатгалын тогтолцооны ач холбогдлыг сурталчлан таниулах нь

төслийн нэг зорилго юм. Японы даатгалын тогтолцоонд өнөөдрийг хүртэлх хугацаанд алдаа оноо, амжилт аль аль нь байсан. Төсөл хэрэгжсэнээр Японы Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын газрын холбогдох мэргэжилтнүүд Монголд ирж ажиллахаар болсон. Даатгуулагч иргэн нийгмийн даатгалын шимтгэлдээ хэдийг, хэрхэн төлөх, ямар хэмжээний тэтгэвэр тооцуулж авах вэ гэх мэт тооцоолол хийх өдөр тутмын үйлчилгээг сайжруулах зөв ойлголттой байх нь чухал гэдгийг онцлов.

Лекцийн дараа сурагчид түүнээс өөрсдийн сонирхсон асуултад хариулт авсан. Тус сургуулийн сурагчид Монгол нийгмийн даатгалын системийг сайжруулахад залуучуудийн үүрэг оролцоо ямар байх ёстой вэ, юунаас эхэлж хийх вэ гэдгийг асуусан. Тэдний асуултад “Япон ч гэсэн ийм асуудалтай тулгарсан. Тухайн үед Япон улс иргэдтэйгээ харилцах тал дээр маш дутагдалтай байсан. Төлөх ёстойлгэдэг болохоос нийгмийн даатгалын учир шалтгааныг тайлбарладаггүй. Танай Засгийн газарч мөн адил учир шалтгааныг тайлбарладаггүй. Тиймээс залуучууд та бүхэн



...“Монголд 65-аас дээш насныхан буюу хүн амд эзлэх өндөр настнуудын хувь өнөөдрийг хүртэл таван хувиас дотогш байсан. Гэтэл насжилтыг урт хугацаанд авч үзвэл, 2100 он гэхэд Монголын хүн амын дөрвөн хүн тутмын нэг нь 65-аас дээш насныхан болох хандлага ажиглагдаж байгаа...

өөрсдөө нийгмийн хамгаалал, нийгмийн даатгалын талаар мэдлэг мэдээлэлтэй бай, ач холбогдлыг мэдэж авах нь чухал. тэгэхээр залуучууд та бүхний хийж чадах зүйл бол энэ талаархи мэдээллийг мэдэж, бусаддаа түгээх юм” гэв. Лекцийн дараа Нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадвархийг бэхжүүлэх төслийн ахлах зөвлөх Ямашита Маморутэй ярилцлаа.

**-Төслийнхөө талаар товч танилцуулахгүй юу?**

-Манай төсөл гурван үндсэн чиглэлээр хэрэгжинэ. Нэгдүгээрт, эрүүл мэнд, нийгмийн даатгалын газартай хамтарч тус газрын үйл ажиллагааг сайжруулахаар ажиллана. Хоёрдугаарт, нийгмийн даатгалын талаар Монголын ард иргэдэд мэдээ, мэдээлэл өгөх, түүний ач холбогдлыг ойлгуулахад чиглэж ажиллаж юм. Гуравдугаарт, тэтгэврийн тогтолцоог сайруулахад төслийн зорилго оршиж байна.

**-Яагаад төслийн талаар ахлах ангийн сурагчдад танилцуулах болсон юм бэ. Бусад ерөнхий боловсролын сургуульд төслийн талаар танилцуулах уу?**

-Миний лекцэнд ч дурдагдсан. Тэтгэвэр гэхээр л урт хугацааны зүйл гэж үздэг. Энэ талаар залуучуудын ойлголт муу. Болоогүй зүйлд юун эрт санаа зовдог юм гэж ханддаг. Гэвч одоо залуу байгаа ч ирээдүйд өндөр настай болно шүү дээ. Мөн ямар нэгэн шалтгаанаар янз бүрийн осол гэмтэлд өртөх магадлалтай. Ийм эрсдлийг бүгд хүчээ нэгтгэж нийгмийн даатгалаараа дамжуулан бие биендээ тусалж дэмжих хэрэгтэй. Энэ нь одоо болоогүй ч ирээдүйд болох

зүйл учраас залуу хүмүүст чухал. Тиймээс би Монголын залууст нийгмийн даатгалын талаар яриа хийсэн. Энэхүү лекцийг Японы ахлах болон их сургуулиудад ч хийсэн. Ер нь Шинэ монгол сургуульд орсон энэхүү лекцээр Монголын оюутан залууст нийгмийн даатгалын ач холбогдолын талаар ойлгуулах ажил маань эхэлж байна. Цаашид маш олон сургуулиудад очиж, лекцээ уншина. Нийгмийн даатгалын газар биднийг дэмжин ажиллахаа мэдэгдсэн.

**-Монголын иргэдэд нийгмийн даатгалын талаархи мэдээлэл хүргэх нь төслийн нэг зорилго гэлээ. Мэдээллийг хэрхэн хүргэх вэ?**

-Ер нь хотод байгаа иргэдээс гадна хөдөө орон нутагт, малчдад энэ талаархи мэдээллийг хүргэнэ. Мөн хүн бүхэн үзээд ойлгох ведио бичлэг хийх, тараах материал бэлдэнэ. Энэ бүхэн төлөвлөгөөнд орсон.

**-Монголын ерөнхий боловсролын сургуулийн “Нийгмийн ухааны” хичээлийн агуулгад нийгмийн даатгал ороогүй байдаг. Японы сургуулиудад байдаг уу?**

-Японы ерөнхий боловсролын сургуульд нийгмийн даатгалын талаар заадаггүй. Энэ талаар бид Эрүүл мэнд, нийгмийн даатгалын газрын даргатай ярилцсан. Түүний үр дүнд ахлах сургуулийн багш нар нийгмийн даатгалын зөв ойлголт хүргэх нь зүйтэй юм гэж шийдсэн. Учир нь багш нар сурагчдад хичээл заадаг. Тиймээс зааж байгаа хүмүүс нь өөрсдөө зөв мэдээлэлтэй байх хэрэгтэй. Тэгэхээр багш нар энэхүү лекцэнд хамрагдах юм. Үүнийг би таатай хүлээж авсан.



# ШУУРХАЙ МЭДЭЭ

## КИНО ТЕАТРУУД ХОЁРООС ДЭЭШ АВРАХ ГАРЦТАЙ БАЙХ ЁСТОЙ

Н.БАТЗАЯА

*НОВГ-ын Гал унтраах асуудал харууцсан чиглэлийн ахлах мэргэжилтэн Д.Монхсайханаас гал түймэртэй холбоотой асуудлаар зарим зүйлийг тодрууллаа.*

**-Сүүлийн үед гал түймрийн дуудлага их ихэрх болсон гэсэн. Одоогийн байдлаар хэчнээн дуудлага ирээд байна вэ?**

-Нийслэлийн Онцгой байдлын газарт он гарсаар гал түймрийн нийт 2030 гаруй дуудлага ирсэн байна. Ойн түймрийн зөрчлийн хэмжээний гурван дуудлага бүртгэгдсэн.

**-Иргэдэд гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар мэдээ мэдээлэл хүргэдэг шүү дээ. Энэ жил ямар ажлыг зохион байгуулсан бэ?**

-Бид оны эхэнд гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг хүргэх, хийж хэрэгжүүлэх ажлынхаа төлөвлөгөөг гаргадаг. Тэгэхээр төлөвлөгөөнийхөө дагуу олон ажлыг зохион байгууллаа. Тухайлбал, бүх албадын сургалтыг зохион байгуулсан. Ерөнхий боловсролын сурагчид, оюутан залуус, ажилчин албан хаагчид, удирдах бүрэлдэхүүн, аж ахуйн нэгжийн гэх мэтчилэн төрөл бүрийн сургалтуудыг явуулсан. Уг сургалтыг сар, улирал тутамд зохион байгуулдаг юм. Түүнчлэн албан хаагчиддаа дотоод сургалт явуулдаг. Хамгийн сүүлд гэхэд өнгөрсөндөрөвдөхдөрөхөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд "Өсвөрийн гал сөнөөгчдийн аварга шалгаруулах тэмцээн"-ийг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулсан. Эхлээд дүүргийнхээ сургуулиуд дунд энэ тэмцээнийг явуулж, шилдгээр шалгарсан нэг сургууль нь бусад дүүргээс

шалгарсан сургуулиудтай өрсөлдсөн. Ингээд тэмцээний хоёрдугаар шатад дүүргүүдээс шалгарсан есөн сургуулийн сурагчид өрсөлдөж, шилдгээ шалгаруулсан. Энэхүү тэмцээнд Багануур дүүргийн ахлах ангийн сурагчид тэргүүн байр эзэллээ. Энэ мэтчилэн сургуулийн хүүхдүүдэд гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх талаархи ойлголт өгөх, тэднийг өөрсдийг нь оролцуулах маягаар мэдээ мэдээллийг хүргэж байна.

**-Хавар намрын улиралд хуурайшилт ихтэй учраас түймэр гарах нь ихэсдэг. Энэ жил ойт хээрийн түймэр гарсан уу?**

-Нийслэлийн хэмжээнд ойн түймрийн гурван удаагийн дуудлага ирсэн. Энэ зун хур бороо элбэгтэй байлаа. Мөн иргэдэд анхааруулга сэрэмжлүүлэг өгч, үргэлж хуулийн хэрэгжилтийг шалгаж, хавар, намрын хуурайшилттай үед ногоон бүсийн эргүүлийг гаргаж байгаа учраас ойн түймэр гарах тохиолдол харьцангуй бага байна. Одоогийн байдлаар ойт хээрийн түймэр гарсан дуудлага байхгүй.

**-Бага насны хүүхэд ахуйн гал түймэрт өртөх нь ихэссэн. Энэ юунаас болж байна вэ?**

-Саяхан Багануур дүүрэгт есөн настай хүүхэд гэртэйгээ шатаж, нас барсан харамсалтай хэрэг гарлаа. Ер нь бид байнга хэлж, ярьж сануулдаг. Бага насны хүүхдийг хараа хяналтгүй орхихгүй байх, гэртээ цоожилж үлдээж болохгүй гэж хэлдэг. Энэ тухай хэлсээр байтал

эцэг, эхчүүд хайхрамжгүй, санамсаргүй, болгоомжгүй үйлдэл гаргаж байна. Энэ мэтчилэн ямар нэгэн шалтгааны улмаас бага насны хүүхэд ахуйн гал түймэрт өртдөг. Хүүхэд гэртээ ганцаараа байхдаа цахилгаанаар тоглох, эсвэл цоожилж үлдэсэнээс болж гарч чадахгүй галд өртөж амиа алдаж байна л даа.

**-Албан байгууллагад гал гарах тохиолдол байдаг.**

**...Саяхан Багануур дүүрэгт есөн настай хүүхэд гэртэйгээ шатаж, нас барсан харамсалтай хэрэг гарлаа. Ер нь бид байнга хэлж, ярьж сануулдаг. Бага насны хүүхдийг хараа хяналтгүй орхихгүй байх, гэртээ цоожилж үлдээж болохгүй гэж ХЭЛДЭГ...**

**Манай улсад үйл ажиллагаа явуулж байгаа томоохон кино театруудын аврах гарц, галын хор стандартын шаардлага хангасан байдаг уу?**

-Ер нь барилга байгууламжид тавих стандарт үйл ажиллагааных нь чиглэлээс хамааран өөр өөр байдаг. Тухайлбал, сургууль, цэцэрлэг, оффисын барилгаас хамаарч стандарт шаардлага нь харилцан адилгүй. Гэхдээ

ямар ч барилга байгууламж аврах зам гарцтай байх ёстой. Ингэхдээ гал гарсан үед хүмүүсийг аюулгүй болгох нөөц гарц гэж байх шаардлагатай. Ер нь хоёроос дээш аврах гарцтай байна гэсэн стандарт бий. Мөн анхан шатны багаж хэрэгслээ өөрсдөө бүрдүүлсэн байх ёстой. Ялангуяа хүн болгоны ашиглаж чадах гал унтраагуурыг 25 мкв тутамд нэг байх шаардлагыг тавьдаг.

**-Нийслэлд үйл ажиллагаа явуулдаг томоохон үзвэр үйлчилгээний газрууд нэг хаалгатай харагддаг. Хаалга байсан ч нөөц хаалгаа үйлчлүүлэгчдээ зааж өгдөггүй. Үүнд шалгалт хийдэг байх?**

-Хүн ам олноор цуглардаг үзвэр, үйлчилгээний газар хамгийн их аюулгүй байдлыг хангасан байх ёстой. Үүнтэй холбогдуулан шадар сайд болон ОБЕГ-ын даргын удирдамж жил бүр гардаг. Энэхүү удирдамжийн хүрээнд гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, галын аюулгүй байдлыг хангасан эсэхэд шалгалт хийдэг. Шалгалтын явцад аюулгүй байдлаа хангаагүй албан байгууллага байвал шаардах хуудас хүргүүлж, дахин биелэлтийн шалгалт хийдэг. Энэ мэтчилэн тухайн байгууллагын аюулгүй байдлыг хангуулдаг. Сүүлийн үед баригдсан байгууллагууд харьцангуй стандарт нормын дагуу баригдсан. Зам гарц, гэрэлтүүлэг нь стандартын шаардлага хангадаг болсон. Гэхдээ томоохон кино театрууд нөөц гарцаа чөлөөтэй байлгадаггүй. Ямар нэгэн аюул осол гарсан үед хүмүүсийг гарахад бэлэн байх ёстой байтал хаалгаа цоожилдог эсвэл урьд нь юм хураачихдаг. Эдгээр зөрчлийг шалгалтаар илрүүлж тухайн үед нь арилгуулдаг.

### СЭРЭМЖЛҮҮЛЭГ

## ИХ ХЭМЖЭЭНИЙ ЦАС ОРЖ, ОРОН НУТГИЙН ЗАМ ЦАСАНД БООГДЖЭЭ

Цас их орж замын гадаргуу халтиргаа гулгаа ихтэй болсон учир Дорноговь аймагт Замын-Үүд-Улаанбаатар чиглэлийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр хязгаарлажээ. Автозам засвар арчлалтын компаниас авто замын хөлдсөн хэсгийг хусаж хөдөлгөөнийг хэвийн болгохоор ажиллаж байна хэмээн Автотээврийн үндэсний төвөөс мэдээллээ. Мөн Чойр-Сайншанд чиглэлийн замыг Аймгийн онцгой байдлын газраас замын хөдөлгөөнийг түр хугацаагаар хаажээ.

## 120 мянгатын автобусны буудал НҮҮНЭ

Өнөөдрөөс 120 мянгатын автобусны буудал зогсоолыг дайран өнгөрч баруун гар тийш эргэх хөдөлгөөн хийдэг 12 чиглэлийн 135 тээврийн хэрэгсэл шинэ автобусны зогсоолд зогсон иргэдэд үйлчлэхээр болжээ. Чингисийн өргөн чөлөөний авто замын ачаалал ихсэж, түгжрэл үүссэнээр улмаар Энхтайваны өргөн чөлөөний нэвтрэх хязгаар нэмэгдүүлж байгаа нь 7, 8, 9 дүгээр сард хийгдсэн судалгааны үр дүнгээс гарчээ. Тиймээс Нийслэлийн Тээврийн газар, ЗХУТ, ЗЦГ, Авто замын газрын хамтарсан "Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, үйл

ажиллагааг удирдан зохион байгуулах" ажлын хэсгээс 120 мянгатын автобусны зогсоолд өөрчлөлт оруулах тус шийдвэр гаргасан байна. Шийдвэрийн дагуу ХУД-ийн 120 мянгатын автобусны буудлыг дайран өнгөрдөг нийтийн тээврийн үйлчилгээний Ч:7, Ч:10, Ч:18А, Ч:7, Ч:32, Ч:34, Ч:44, Ч:50, Ч:53, Ч:56, Ч:58, ХО:6, ХО:7 гэсэн чиглэлүүдийн замналын зураглалд өөрчлөлт орж хуучин зогсоолоос 300 метрийн зайд шинэ автобусны зогсоолыг тусгаж өөрчлөлт оруулаад байна. Харин Зайсан чиглэлд буюу Ч:8, Ч:42, Ч:52, Ч:55 чиглэлүүд хуучин буудал зогсоолоор хэвээр үйлчлүүлэх юм.

## Хүүхдүүд санаатайгаар гал тавьжээ

Бага насны хүүхдүүд санаатайгаар гал тавьж, машинд ачиж явсан өвсийг шатаажээ. Тодруулбал, өнгөрсөн пүрэв гарагт бага насны хүүхдүүд өвс ачсан машинд шүдэнз зурж гал түймэр тавьсан байна. ХУД-14 хороонд "Өлзийтийн МТ" ППС-ын гадна автомашинд ачсан өвс шатаж байна" гэсэн мэдээллийг цагдаагийн байгууллага авч шалгажээ. Шалгалтаар Дорноговь аймгийн Замын-Үүд сумын харьяат А-ийн "Dewoo" автомашинд ачиж явсан 480 боодол өвсийг ХУД-14 хороонд суух найман настай эрэгтэй С, А, Т нар гал тавьсан нь илэрчээ. Тус хэргийг дүүргийн цагдаагийн хэлтсээс шалгаж байна.

## Угаартаж болзошгүй байсан 98 иргэнийг аварчээ

Баянгол дүүргийн 11 дүгээр хороо, 43 дугаар байрны суурийн давхарга утаа гараад байна гэсэн дуудлага өнгөрсөн баасан гарагт иржээ. Тус дуудлагын дагуу Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах 10 дугаар ангийн бүлгийг очиход суурийн давхарт хэрэглээний халуун ус халаах зориулалттай нэг тн багтаамжтай дөрвөн ширхэг халаагчийн гадна дулаалга шатаж байсныг нэмэлт дуудлагаар 10 дугаар ангийн хоёрдугаар тасгийг гаргаж албан хаагчид шуурхай ажиллаж унтраасан байна. Гал түймрийн улмаас тус байрны 1-9 давхар бүхэлдээ утаанд автсан байсан тул иргэдийг утаанд хордож амиа алдахаас урьдчилан сэргийлж 98 иргэнийг гарган НЯТТТ-ийн эмчтэй хамтран 69 иргэнд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлжээ. Мөн хордсон байж болзошгүй дөрвөн сартайгаас найман насны 14 хүүхдийг ЭХЭМҮТ-д хүргэж яаралтай үзлэгт хамруулсан байна. Эмнэлэгт хүргэгдсэн хүүхдүүдийн биеийн байдал 21:30 цагт сайжирч хэвийн болсон тул эцэг, эхэд нь хүлээлгэн өглөө гэж нийслэлийн Онцгой байдлын газраас мэдээллээ.

### PHOTO NEWS



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

*"Спортлог Улаанбаатар" өдөрлөг өнгөрсөн бялба гарагт Сүхбаатарын талбайд боллоо. Энэ үеэр Үндэсний цэцэрлэгт хүрээнд бүх нийтийн гүйлтийн тэмцээн болсон бөгөөд 3000 гаруй тамирчин 5,10,21,42 километр уралдлаа. Тус тэмцээний эхний гурван байр эзэлсэн тамирчид, алт, мөнгө, хүрэл медаль, мөнгөн шагналын эзэн болсон юм.*



## Самар түүж яваад ууланд төөрчээ

Намрын улиралд иргэд самар, жимс түүх, найз нөхөд, анги, хамт олноороо ууланд алхаж явах үедээ газрын баримжаа алдсаны улмаас төөрөх тохиолдлууд гарсаар байна. Иймд, иргэд уул, модонд батлагдсан зам, маршрутаар бүлэг, багийн зохион байгуулалтад орж явах, зам, маршрутаас хазайж гарахгүй байх, холбоо, мэдээлэл, зүг чиг баримжаалах хэрэгслэлтэй явахыг ОБЕГ-аас анхааруулж

байна. Хамгийн сүүлд гэхэд Булган аймгийн Хангал сумын Сөрт багийн Бүрэнгийн нуруу гэдэг газар иргэн Б энэ сарын 4-ний өдрийн 09.00 цагийн орчимд самранд явж байгаад модон дунд төөрч сураггүй болсон тухай мэдээллийн дагуу аймгийн Онцгой байдлын газрын албан хаагчид эрэн хайжээ. Тэд төөрсөн иргэнийг очигдөр Сөрт багийн Сөрт гэдэг газраас эсэн мэнд олсон байна. Мөн тус

аймгийн Сэлэнгэ сумын Ингэт багийн Хантайн баруун бэлсэг гэдэг газар иргэн Б аравдугаар сарын 4-ний өдрийн 18.00 цагийн орчимд жимс түүж явж байгаад модон дунд төөрч сураггүй болжээ. Аймгийн Онцгой байдлын газрын албан хаагчид, ар гэрийнхний хамт эрэн хайх ажиллагааг зохион байгуулан ажиллаж "Хантайн баруун бэлсэг" гэдэг газраас иргэнийг эсэн мэнд олсон байна.





СОНИРХУУЛАХАД

# Алена Раева: Би өөрийгөө ялагч болно гэж бодож байсангүй

Э.МӨНХ

Монгол Улсад анх удаа зохион байгуулсан олон улсын хэмжээний "Face of Beauty International 2016" гоо бүсгүйн тэмцээний ялагчийн титмийг ОХУ-ын гоо бүсгүй хүртэж, дэд байрт Замби, гуравдугаар байранд Филиппиний мисс шалгарлаа. Харин Монгол Улсаа төлөөлөн оролцсон манай улсын гоо бүсгүй Э.Урангоо дөрөвдүгээр байрт шалгарсан юм. "Корпорэйт" зочид буудлын Концертын их танхимд болсон энэхүү тэмцээний эцсийн шатны шалгаруулалт үндэсний хөгжмийн "Хөсөгтөн" хамтлагийн тоглолт болон олон улсын гоо бүсгүйчүүд нэгэн зэрэг хамтдаа монгол үндэсний бүжиг бүжиглэж толилуулснаар эхэлсэн. Монгол Улсад анх удаа зохиогдсон олон улсын хэмжээний "Face of Beauty International 2016" гоо бүсгүйн

үүсгэн байгуулагч Пави Винтура нар шүүн явуулсан юм. Хоёр долоо хоногийн турш Улаанбаатар хотноо үргэлжилсэн тус тэмцээний урьдчилсан шалгаруулалтын үеэр "Шилдэг үндэсний хувцастай гоо бүсгүй" гээр Филиппин, "Шилдэг усны хувцастай 15 гоо бүсгүй"-д Алтгайн Бүгд Найрамдах улс, Эквадор, Унгар, Молдав, Монако, Филиппин, Мьянмар, Филиппин, Орос, Замби, Словак, Швейцарь, Бельги, Косово, Прагвай улсын бүсгүйчүүд шалгарч Акуа Фитнесс төвийн захирал Укагийн урласан усны хувцсыг өмсч тайзнаа гарч, Замби улсын миссүүд түрүүлсэн бол "Шилдэг үдшийн гоёл" гээр дашинзтай гоо бүсгүй" гээр Монголын гоо бүсгүй тодорсон юм. Харин БОАЖЯ-ны нэрэмжит "Мазаалайн элч" шагналыг Самоа улсын гоо бүсгүй хүртлээ. Тэмцээний үеэр Украины 2007

"Сайн үйлсийн гоо бүсгүй"-Швейцарь  
 "Спортлог мисс"-Монако  
 "Үзэгчдийн таашаалд нийцсэн мисс"-Филиппин  
 "Нөхөрсөг мисс"-Сибирь  
 "Фото зургийн дүр төрхтэй мисс"-Япон  
 "Аялал жуулчлалын элч гоо бүсгүй"-Парагвай  
 "Өсвөр насны мисс"-Мьянмар улсын миссүүд тодорсон юм.

Гоо бүсгүйн тэмцээний тэргүүн миссийн титмийг хүртсэн ОХУ-ын мисс Алена Раевагийн сэтгэгдлийг сонслоо. Тэрбээр "Үнэнийг хэлэхэд би өөрийгөө ялагч болно гэж бодож байсангүй. Гэхдээ надад үнэхээр сайхан байна. Би Монголд гайхамшигтай сайхан өдрүүдийг өнгөрөөлөө. Энэ миний амьдралын хамгийн мартагдашгүй мөч байх болно. Зөвхөн ялагч болсондоо ч биш энд өнгөрүүлсэн



Грэн эрхлэн Г.АРИУНЖИН



тэмцээнийг "Face of Beauty International" тэмцээнийг үүсгэн байгуулагч Мила Мануэль, "Face of Beauty International 2016" тэмцээнийг Монгол Улсад зохион байгуулах төслийн удирдагч, "Монгол гоо сайхан" холбооны тэргүүн Ж.Анхбаяр, Украины 2007 оны мисс, дуучин, жүжигчин Валерия Лукьянова, Монгол талын шүүгч, хөтлөгч П.Анужин, "Face of Beauty international 2015" тэмцээний тэргүүн байрын шагналт, Унгарын мисс Далма Карман болон тус тэмцээний Miss Teen номинацийн ялагч Н.Сото, Missology сайтын

оны мисс, дуучин, жүжигчин, загвар өмсөгч Валерия Лукьянова өөрийн дууг толилуулсан нь олны анхаарлыг татсан юм. Түүнчлэн тэмцээний өмнөх шалгаруулалтын бусад номинациудад шалгарсан гоо бүсгүйчүүдэд Монгол талын шүүгч П.Анужин, Унгарын мисс Далма Карман, Шүүгч Пуэрто Рикогийн өсвөр насны мисс Н.Сота, Валерия Лукьянова, Пави Винтура нар дараах номинациудад тэргүүлсэн гоо бүсгүйчүүдэд шагнал гардуулсан юм. Үүнд:

"Авьяаслаг мисс"-Монгол  
 "Ухаалаг мисс"-Орос

цаг мөч бүхнийг би мартахгүй. Монгол Улсад баярлалаа, тэмцээний зохион байгуулагчид болон надад тусалсан хүн бүхэнд баярлалаа. Хоёр долоо хоног маш хурдан өнгөрлөө. Өдөр бүр бэлтгэл, аялал зугаалгатай байлаа. Маш олон хүнтэй танилцаж, тэд надад үнэхээр сайхан сэтгэгдэл үлдээлээ. Тиймээс энэ бүхэн дуусч байгаад надад гунигтай байна. Гэхдээ би 2016 оны мисс гэдэг цолтойгоо бүтэн жил явна шүү дээ" хэмээсэн юм. Ийнхүү хоёр долоо хоног үргэлжилсэн "Face of Beauty International-2016" тэмцээн өндөрлөлөө.

ОДДЫН АМЬДРАЛ

## БРЭД ПИТТ хүүхэдгээ гар хүрч байгаагүй

Холливудын хүчирхэг гэр бүлийн тоонд багтаж байсан Брэд Питт, Анжелина Жолли нар өнгөрсөн сард салж буйгаа зарласан билээ. Тэдний салалтын шалтгаан Брэдийн таагүй зан авиртай холбоотой байсан тухай хэвлэлд мэдээлж байсан. Мөн жүжигчин залууг хүүхэддээ гар хүрсэн байж болзошгүй гэх таамаглалыг дэвшүүлж байсан юм.

Тодруулбал, эцэг эхтэйгээ хамт хувийн онгоцонд зорчиж явахдаа ам муруйны улмаас ууган хүү Маддокст гар хүрсэн байж магадгүй гэх "бор шувуу" ч шар хэвлэлд хөвөрч байсан билээ. Нислэгийн үеэр Питт 15 настай өргөмөл хүүтэйгээ нэлээд ширүүн маргалдаж, чангаар хашгирч байсныг гэрчүүд харсан байдаг. Үүнтэй холбогдуулан Брэд Питт ч өөрийг нь Холбооны мөрдөх товчооноос хүүхдээ үнэхээр зодсон эсэхийг шалгуулна гэх мэдээллийг өгч байсан. Тэгвэл гэрчүүд гар хүрч санаатайгаар гэмтээж байгаагүй гэдгийг баталсанаар жүжигчин Брэд Питт гэм буруугүй болох нь тогтоогдсон тухай "TMZ" сайт мэдээлсэн байна.



## Шон Пенн 24-тэй бүсгүйтэй болзож эхэллээ

Холливудын нэрт жүжигчин 56 настай Шон Пенн найз бүсгүйтэй болсон талаар "www.dailymail.co.uk" мэдээллээ. Пенн өөрөөсөө 32 насаар дүү залуу жүжигчин Лела Жорж гэх бүсгүйтэй болзож болжээ. Хос Хавай аралд амарч байхдаа гэрэл зурагчдын дуранд өртсөн байна. Лелагийн аав Австралийн жүжигчин Карин Ван Донк бол ээж нь Итали жүжигчин Гретта Скаччи гэнэ. Тэд охиныхоо найз залуутай нас чацуу аж. Пенн өнгөрсөн онд эхнэр жүжигчин Шарлез Тероноос салсан билээ. Жүжигчин эрийг экс эхнэр дуучин Мадоннтай эргэн нийлсэн хэмээн хэвлэлүүд мэдээлж байсан ч уг мэдээллийг саяхан хоёр тал үгүйсгэсэн юм.

Бидэнд тохиолдсон

Mstyle MD Mking



ХҮНДЭХН ХӨГТЭЙ ЯВДЛУУД

Манай өвөө 80 шахаж яваа. Насаараа автобус 1 ТӨХК-д жолооч хийсэн буурай бий. Чих нэлээд хатуу. Гэсэн ч зурагт үзэх тун дуртай юм л даа. Нэг удаа эмэгтэйчүүдийн ариун цэврийн хэрэгзүйлийн реклам гарч байна аа. Бүхэл шөнийн турш тайван амгалан нойрсуулна гээд л. Тэгсэн "Өвөө нь унтаж чадахгүй байгаа. Энэ л өвөөд нь хэрэгтэй юм байна. Өвөөдөө авч өгөөрэй. Хаана зарж байгаа гэнэ үү" гэдэг байгаа. Одоо би яана. Ха ха ха

**ТЭНГИС**

Жирийн нэгэн албан хаагч залуу Итгэл нэг л өдөр гэнэтийн том амжилтанд хүрч, "сайдын багийн хүн" болон түүний гарын үсэг олон хүний амьдралыг шийдэх болно...

Риогийн олимпиос мөнгөн медаль хүртэж эх орныхоо нэрийг дэлхийн тавцанд гаргасан жүдоч Д.Сумьяагийн амьдралаас сэдэвлэн бүтээв.

Жакоб хүүд нэгэн захиа ирсний дагуу нууцлаг арал дээр очно. Тэнд төрөл бүрийн өвөрмөц чадвартай хүүхдүүд амьдардаг Хадагтай Перегриний өвөрмөц хүүхдийн ордон байлаа.

УСГААГАА ГЭРЛЭГЭХ ДЭНН БИЛЭЭ